



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН УДИРДАМЖ

**АЛБАН ХЭРЭГЦЭЭНД**

УЛААНБААТАР ХОТ  
2023 он



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГ ЖҮҮЛЭХ НЭГДСЭН УДИРДАМЖ

## Боловсруулсан:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга **Б.Алтантулга**
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн түншлэл, гадаад төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн **Э.Хатантуул**
- Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төслийн Хөдөлмөр эрхлэлтийн Зохицуулагч **Ч.Долгорсүрэн**
- Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төслийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх **Г.Ганзориг**

## Хянан тохиолдуулсан:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга **С.Дамбий**

## Ерөнхий мэдэгдэл

Тус гарын авлагыг Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэсэн болно. Гарын авлагын агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү гарын авлагад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно.

ISBN код

ISBN : 978-9-91999-385-6



9 789919 993856



Европын Холбоо  
санхүүжүүлэл



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага




Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



UN  
DP





# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН УДИРДАМЖ

# ГАРЧИГ

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР) 09**

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 09

ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 09

**НЭГ.** ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ 10

**ХОЁР.** ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 11

**ГУРАВ.** САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 13

**ДӨРӨВ.** ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 16

**ТАВ.** ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 19

**ЗУРГАА.** ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 21

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН 20

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)-НЫ ХҮРЭХ ҮР ДҮН 22

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН УДИРДАМЖ, ЗАРДЛЫН ЖИШИГ ХЭМЖЭЭ 31**

**НЭГ.** ЗОРИЛГО 32

**ХОЁР.** НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ 33

**ГУРАВ.** ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ 35

**ДӨРӨВ.** ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ 38

**ТАВ.** ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 41

**ЗУРГАА.** САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 53

**ДОЛОО.** ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 64

**НАЙМ.** ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 76


**ЕС.** ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН 80

**АРАВ.** ТӨСВИЙН ХӨТӨЛБӨР ҮР ДҮН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ 81

# ТОВЧИЛСОН ҮГ

<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж байгууллага
<b>ЕХ</b>	Европын холбоо
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ХЭБ</b>	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
<b>ХЭҮЗ</b>	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
<b>ХНХСҮСИ</b>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
<b>ХБИ</b>	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
<b>ХХҮЕГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
<b>ХХҮХ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
<b>ЗГҮАХ</b>	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
<b>ЗГҮАХХАХТ</b>	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
<b>МУХТЖҮЧ</b>	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ХЭДС</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
<b>ХЗЗ</b>	Хөдөлмөрийн зах зээл

## ИРГЭН ТӨВТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАГВАР



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАМЫН ЗУРАГЛАЛ







## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г нэгдүгээр, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүнг хоёрдугаар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хүрэх үр дүнг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Дамбий)-т, хэрэгжилтийг зохион байгуулж, шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг ханган тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Т.Бадрахбаяр), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (Ц.Нямсүрэн), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (Б.Батбаатар)-д тус тус даалгасугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлд тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД



Т.АЮУРСАЙХАН



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд дараах үйл ажиллагаа буюу үйлчилгээ, арга хэмжээг хөдөлмөрийн насны хүн ам, зорилтот бүлэгт зориулан тухайн иргэний хэрэгцээнд үндэслэн сонгон хэрэгжүүлнэ. Үйлчилгээ, арга хэмжээг “Үйлчлүүлэгчид суурилсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ерөнхий зарчим, дараалал, зураглал”-ын дагуу зохион байгуулна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулахдаа тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлог, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах чиглэлтэй уялдуулан (заавал, сонголтоор, ялгаатай) хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг энэхүү баримт бичигт дурдсан хэлбэр агуулгаар зохион байгуулна.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ (цаашид “нэгдсэн удирдамж” гэх)-г Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Нэгдсэн удирдамжид нэр томьёо, ойлголт тодорхойлолт, үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим, дараалал, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, үйлчилгээ, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгана.

# 1.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан болон Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр тодорхойлсон бусад үйлчилгээ байна.

Үүнд:

### 1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ.

### 1.2. Ажилд зуучлах үйлчилгээ

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучлах үйлчилгээ үзүүлнэ. Ажилд зуучлах үйлчилгээ дараах үе шаттай байна:

- 1.2.1. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling);
- 1.2.2. Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах;
- 1.2.3. Ажилд зуучлах (байнгын, цагийн, түр).

### 1.3. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь иргэд, бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ. Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллээр хангахад дараах арга хэрэгсэл ашиглана:

- 1.3.1. Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр мэдээлэл өгөх;
- 1.3.2. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;
- 1.3.3. Мэдээллийн самбар, гудамж, талбайн мэдээллийн дэлгэц;
- 1.3.4. Хэвлэмэл материал (ном, лавлагаа, мэдээллийн эмхтгэл, товхимол, сэтгүүл);
- 1.3.5. Бусад.

# 2.

## ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн ажиллах хүчнийг мэргэжлийн болон суурь ур чадварын сургалтаар дамжуулан бэлтгэх, цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх талаарх мэдлэгийг олгох замаар хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлэхэд уг арга хэмжээний зорилго оршино.

Сургалтын агуулга, хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт батална. Сургалтын хөтөлбөр нь чадавхжуулах болон чадамжид суурилсан хэлбэртэй байна. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын арга хэмжээг дараах төрөл, хэлбэрээр зохион байгуулна.

### 2.1. Суурь ур чадварын сургалт

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох хүрээнд Ажлын байран дахь харилцааны ур чадвар; Сэтгэл зүйн сургалт; Анкет бэлтгэх; Ажлын ярилцлагад бэлтгэх; Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн бодлогод нийцсэн тест, асуулгад бэлтгэх; Ажлын байр, бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэлтэй танилцуулах зэрэг агуулгаар зохион байгуулна.

### 2.2. Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадварыг иргэнд богино хугацаанд олгох, давтан сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. Сургалтыг танхимын болон үйлдвэрлэл дээрх хэлбэрээр зохион байгуулна.

### 2.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт

#### 2.3.1. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх болон олгосны дараах сургалт.

Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээний хүрээнд иргэн, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн мэдлэг олгох, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх тухай сургалтыг зохион байгуулна.



### 2.3.2. Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт, туршлага солилцох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.

## 2.4. Залуучуудын сургалт, зөвлөгөө<sup>1</sup>

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын загвар, стандартын дагуу суралцагч төвтэй, цахим сургалтын хэв шинжийг агуулсан зургаан модуль бүхий<sup>2</sup> сургалтыг зохион байгуулна.

## 2.5. Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт

2.5.1. Эмэгтэйчүүдийн гэрээс, зайнаас болон цахимаар ажиллах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр хөдөлмөрийн харилцааны талаарх мэдлэг олгох, мэргэжлийн, суурь болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна.

<sup>1</sup> Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвүүдэд зохион байгуулна.

<sup>2</sup> Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын "In Business" сургалтын модуль

# 3.

## САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бусад холбогдох дэмжлэг үзүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

### 3.1. Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг

#### 3.1.1. Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг

Сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуй, бичил бизнес үйлдвэрлэл, үйлчилгээ<sup>1</sup> эрхлэх хүсэлтэй 30 ба түүнээс дээш насны иргэнд<sup>2</sup>, мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчид<sup>3</sup> 5.0-10.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэлх сарын хугацаатай олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

#### 3.1.2. Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох

Санхүүгийн дэмжлэгийг зайнаас, түргэн, шуурхай олгох хүрээнд 1.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг туршилтын байдлаар финтек технологи (fintech) ашиглан иргэн, аж ахуй эрхлэгчдэд олгоно.

### 3.2. Малчдыг малжуулах



#### 3.2.1. Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох

21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийг 5.0 сая хүртэлх үнийн дүнтэй тэнцэхүйц мал олгох арга хэмжээнд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хамруулна.

#### 3.2.2. Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах

Улаанбаатар хот болон аймгийн төвөөс суманд, сум хооронд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчнаар ажилд зуучилж, 4.0 сая төгрөгийн үнийн дүнтэй тэнцэхүйц мал олгох арга хэмжээнд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хамруулна.

<sup>1</sup> “Үйлчилгээ” гэдэг нь худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгааг хамааруулахгүй.

<sup>2</sup> Шалгаруулах үйл ажиллагааг “Нэгдсэн удирдамж”-аар зохицуулна.

<sup>3</sup> Санхүүгийн дэмжлэгийг төгсөгчид олгох бол тухайн орон нутагт санхүүгийн дэмжлэг олгох зорилгоор хуваарилсан хөрөнгийн 2 хувиас хэтрэхгүй хөрөнгийг зарцуулж болно.



### 3.3. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох

- 3.3.1. Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аймаг, дүүргийн шилдэг гарааны бизнест олгоно. Улсын хэмжээний гарааны бизнесүүдэд 1 дүгээр байр (нэг баг) 20.0 сая, 2 дугаар байр (хоёр баг) 17.0 сая, 3 дугаар байр (гурван баг) 15.0 сая төгрөгийг тус тус эргэн төлөх нөхцөлгүйгээр олгоно.
- 3.3.2. Гарааны бизнесийн санааг баяжуулах, өрсөлдүүлэх, хөгжүүлэх зэрэг арга хэмжээг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар зохион байгуулна.



### 3.4. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг

Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ахмад (өндөр настны, цэргийн, хөнгөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон хүн) настанд 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 4.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.



### 3.5. Ажил олгогчийг дэмжих

- 3.5.1. Ажил олгогчоос ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, тухайн иргэнийг ажлын байранд нь тогтвортой ажиллуулахыг урамшуулах зорилго бүхий ажил олгогчийг дэмжих урамшуулал олгоно.
- 3.5.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлснээс хойш ажил идэвхтэй хайж байгаа, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадаагүй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг ажлын байны тоогоор тооцож нэг удаа олгоно.
- 3.5.3. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7) иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.





### 3.6. Түрээсийн дэмжлэг үзүүлэх

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, газар дээрх нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт<sup>4</sup>ийг төлбөр төлсөн баримтын дүнгээр нөхөн олгоно.<sup>5</sup>

### 3.7. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн болон бусад дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт борлуулалтын цэг ажлуулах, улсын хэмжээнд хамгийн өндөр ашиглалт хандалттай 2 хүртэлх хувийн хэвшлийн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллана.

### 3.8. Хүүхэд харах төвийн түрээсийн болон бусад дэмжлэг үзүүлэх

Хүүхэд харах үйлчилгээ явуулж байгаа төвд жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт болон бусад дэмжлэгийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.<sup>6</sup>

<sup>4</sup> "Нэгдсэн удирдамж"-ийн зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

<sup>5</sup> Цахим хуудасны хандалтыг холбогдох төрийн байгууллагын хандалтын мэдээлэлд үндэслэнэ.

<sup>6</sup> "Нэгдсэн удирдамж"-ийн зардлын жишиг хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

# 4.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах, ажил олгогчийг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг (дохионы хэлмэрч, ажлын байрны тохируулга г.м) хэрэгжүүлэх зорилготой.

### 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ (Job Coaching)

4.1.1. Цогц арга хэмжээ<sup>1</sup> нь дараах үе шаттай байна.

а) Бэлтгэл үе;

б) Төвлөрсөн дэмжлэгийн үе;

в) Дэмжлэгийг аажмаар багасгах үе;

г) Тогтвортой байдлыг дэмжих үе.

### 4.2. Санхүүгийн дэмжлэг

4.2.1. Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг



Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа (давхар хөдөлмөр эрхэлдэггүй) хүний боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 5.0-10.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаанд 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй олгоно. Иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.

4.2.2. Төрийн бус байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр 3-аас доошгүй жил байнгын үйл

<sup>1</sup> Ажлын байрны дадлагажуулагчийн тавигдах шаардлага, ажиллах аргачлал, цогц арга хэмжээний зөвшөөрөгдөх зардлын ангилал, түүний жишиг үнэ, дадлагажуулагчийн нэг цагийн ажлын хөлсний үнэлгээ зэргийг "Нэгдсэн удирдамж"-аар зохицуулна.

ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын боловсруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нь нийцсэн тохируулгатай ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах төслийг сонгон шалгаруулж, нэг ажлын байранд 10 сая хүртэл төгрөгөөр тооцон, барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаанд 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгээр олгоно. Сонгон шалгаруулалтыг гурван үе шаттай зохион байгуулна.

#### 4.2.3. Аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах ажил олгогчдын төсөлд нэг ажлын байранд 10.0 сая хүртэл төгрөгөөр тооцон, барьцаагүй, хүүгүй, 30.0 хүртэл сая төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгээр олгоно. Сонгон шалгаруулалтыг гурван үе шаттай зохион байгуулна.



### 4.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт (өмнөх ба дараах)

Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан хүн, аж ахуйн нэгжид шаардлагатай тохиолдолд аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулна.

### 4.4. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт

4.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн ур чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдүүлсэн мэргэжлийн сургалтын байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд модуль хэлбэртэй, тусгайлсан сургалтын хөтөлбөртэй<sup>2</sup>, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

4.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан мэргэжлийн чадамж эзэмшүүлэх танхимын болон үйлдвэрлэл дээрх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл сонирхол, мэргэжил ур чадварт нь тохирсон сургалтын төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна. Энэ арга хэмжээний хүрээнд хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хэрэгцээ шаардлагатай нэмэлт сургалтыг хийж болно.



### 4.5. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг

4.5.1. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй хүн, мөн нийт ажилтны 50-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй аж ахуйн нэгж, байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, бизнес инкубатор төвийн бойжигчид тухайн жилийн 6 хүртэл сарын хугацаанд түрээсийн төлбөрийн дэмжлэгийг олгоно.

<sup>2</sup> Сургалтын хөтөлбөрийг ХНХСҮСИ-ээс боловсруулан батална.



4.5.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах ажилд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дэмжлэг үзүүлж ажиллана.

#### 4.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг

4.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангаж, цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын төрийн бус байгууллагад байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.

4.6.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон хувиас илүү гарсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас илүү гарсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг тус бүр нэг удаа олгоно.

#### 4.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа

4.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх;

4.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа хийж, эрх зүйн орчин, дүрэм журмыг сайжруулах тухай санал боловсруулах;

4.7.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх;

4.7.4. Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах;

4.7.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн ур чадварын уралдаан “Абилимп”-д бэлтгэх, оролцуулах боломжоор хангах ажлыг зохион байгуулах;

4.7.6. Бусад холбогдох үйл ажиллагаа.

# 5.

## ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Ногоон хөгжлийн болон нийтийн шинж чанартай ажилд ажилгүй иргэдийн оролцох боломжийг хангах, иргэдийг эх орныхоо байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулах чиглэлээр ажлын байраар хангаж, ажилгүй, ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн иргэдэд түр хугацааны хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

### 5.1. Мод тарих<sup>1</sup>

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, ажилгүй иргэдийн оролцоог хангах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих, суулгах үйл ажиллагааг зохион байгуулна.



### 5.2. Нийтийг хамарсан ажил

Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг ажилгүй болон ажилд ороход хүндрэлтэй иргэнийг хамруулна.



### 5.3. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ<sup>2</sup>

Ахмад мэргэжилтний ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ (сургалт, ментор, дадлагын хэлбэрээр)-г үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор холбон зуучлах байдлаар зохион байгуулна.

### 5.4. Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ

Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг холбоотой хамтран ажиллах гэрээний

<sup>1</sup> “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ.

<sup>2</sup> Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

үндсэн дээр зөвлөх үйлчилгээ зохион байгуулна. Тухайн холбоо нь зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөх үйлчилгээний захиалгад үндэслэн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж, төсөлд хамрагдах ахмад мэргэшсэн зөвлөх мэргэжилтнүүдийг "Ахмад мэргэшсэн зөвлөхүүдийн нэгдсэн мэдээллийн сан"-д бүртгэнэ.

#### **5.5. Хүүхэд хамгаалагч үйлчилгээ**

Аймаг, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс нь боловсролын байгууллага, хүүхдийн байгууллага, цэрэг, цагдаагийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 65 хүртэлх насны ахмад настныг хүүхэд хамгаалагчаар сонгон авч, сургалтад хамруулах ба хүүхэд хамгаалагч нартай хамтран ажиллах сайн дурын ажилтнуудыг мэдээллээр ханган, ажиллах хүсэлтэй иргэдтэй гэрээ байгуулан ажиллана.

# 6.

## ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Засгийн газрын бодлого хөтөлбөртэй уялдсан байдлаар цаг үеийн шинж чанартай тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ байх бөгөөд хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагуудын хэрэгжүүлэхээр тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын болон дэмжлэг нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх цаг үеийн шинж чанартай арга хэмжээ, төсөл байна.

- 6.1.** Засгийн газраас болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж, хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллана.
  - 6.1.1. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;
  - 6.1.2. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
  - 6.1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх;
  - 6.1.4. Өмнөх мэдлэг, ур чадварын үнэлгээ - RPL (Recognition of Prior Learning)-г зохион байгуулах;
  - 6.1.5. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;
  - 6.1.6. Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үйлчилгээ<sup>3</sup> үзүүлэх;
  - 6.1.7. Бусад.

<sup>3</sup> Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/135 дугаар тушаалд нийцүүлэн хэрэгжүүлнэ.



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСВИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

Дунд хугацааны бодлогын зорилт	Тогтвортой хөгжлийн зорилго	Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн	Төсвийн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт	2022 он	2023 он
				Суурь түвшин	Зорилтот түвшин
<p><b>ЗГҮАХ 2.5.6.</b> “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.</p> <p><b>ЗГҮАХХАХТ 2.5.6.4.</b> Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Үйлчлүүлэгч төвтэй аргачлал”-ыг нэвтрүүлж цахимжуулна;</p>	Зорилт 8.5. 2030 он хүртэл эрэгтэй, эмэгтэй хүн бүр тэр дундаа залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх	<p><b>1.</b> Бүртгэлтэй ажилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй ажлын байранд зуучилсан байна.</p>	<p><b>1.</b> Шинээр байнгын ажилтай болсон хүний тоо</p>		
<p><b>ЗГҮАХ 2.5.9.</b> Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p> <p><b>ЗГҮАХХАХТ 2.5.9.1.</b> Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.</p>		<p><b>2.</b> Хувь хүний хандлага, зөөлөн ур чадвар, аж ахуй эрхлэх болон цахим орчинд ажиллах чадвар сайжирснаар ажилтай болно.</p>		16,552	17,000
<p><b>ЗГҮАХ 2.5.14.</b> Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.</p> <p><b>ЗГҮАХХАХТ 2.5.14.2.</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд олгохжижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасган хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>		<p><b>3.</b> Санхүүгийн дэмжлэг, ажлын байрны ба түрээсийн дэмжлэг авч аж ахуй эрхэлж хувиараа хөдөлмөр эрхлэх болсон иргэдийн тоо нэмэгдсэн байна.</p>	<p><b>2)</b> Хувиараа хөдөлмөр эрхэлж эхэлсэн хүний тоо</p> <p><b>3)</b> Хадгалагдсан ажлын байрны тоо</p>	5,191	4,603

<p><b>ЗГҮАХХАХТ 2.5.14.3.</b> Зорилтот бүлгийн иргэдийн хувиараа аж ахуй, гарааны бизнес эрхлэхийг дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй, эргэн төлөлтийн санхүүгийн дэмжлэг болон бусад шинэ арга дэмжлэгийг хэрэгжүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p>					
<p><b>ЗГҮАХХАХТ 2.5.6.4.</b> Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг нэвтрүүлж цахимжуулна;</p>		<p><b>4.</b> Бүртгэлтэй ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж, орлоготой болгосон байна.</p>	<p><b>4)</b> Түр ажлын байртай болсон хүний тоо</p>	7,605	<b>8,000</b>
<p><b>ЗГҮАХХАХТ 2.5.9.2.</b> Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.</p>		<p><b>5.</b> Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p><b>5)</b> Ажилтай болсон ХБИ-ний тоо</p>	1,225	<b>1,082</b>
<p><b>МУХТЖҮЧ 2.6.1.</b> Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгоно.</p>		<p><b>6.</b> Хөдөлмөрийн харилцааг сайжруулж, ажлын байрыг зохистой болгох ажил олгогчийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлсэн байна.</p>	<p><b>6)</b> ХХҮГ/Х-ээс зохион байгуулсан сургалт, мэдээлэл, зөвлөгөөнд хамрагдаж ойлголт сайжирсан ажил олгогчийн тоо</p>	4,988	<b>5,000</b>

**ЗГҮАХ** – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

**ЗГҮАХХАХТ** – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

**МУХТЖҮЧ** – Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)-НЫ ХҮРЭХ ҮР ДҮН

Үйл ажиллагаа	Үйлчилгээ, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	2022 он	2023 он			
			Суурь түвшин	Зорилтот түвшин			
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээнд хамруулсан хүний тоо	30,253	<b>25,654</b>		
		2	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгээр зохион байгуулсан зөвлөх үйлчилгээнд хамруулсан хүний тоо	62,536	<b>31,288</b>		
	Ажилд зуучлах үйлчилгээ	Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling)	3	ХХҮГ-аар үйлчлүүлсэн ажилгүй эсхүл ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэх иргэдээс профайлинг үйлчилгээнд хамруулсан хүний тоо	12,017	<b>39,000</b>	
			4	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах	10,730	<b>15,880</b>	
		Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	5	Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажлын байранд зуучлагдаж, 3 сараас доошгүй хугацаанд НДШ төлж, ажилласан хүний тоо	18,179	<b>19,000</b>
				6	Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо		<b>42,153</b>
				7	Цагийн ажлын байранд зуучлагдсан хүний тоо	8,921	<b>9,510</b>
				8	Түр ажлын байранд зуучлагдсан хүний тоо		

ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	Суурь ур чадварын сургалт		9	Суурь ур чадварын сургалтад хамрагдсан хүний тоо	6,894	<b>6,909</b>
	Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт	Танхимын сургалт	10	Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдээс төгсөлтийн шалгалтад тэнцэж чадамжийн гэрчилгээ авсан суралцагчийн хувь	72.3	<b>75.0</b>
		Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт	11	Мэргэжлийн сургалтад (танхимын болон үйлдвэрлэл дээрх) хамрагдсан иргэдийн тоо	3,241	<b>3,396</b>
		Суралцагчид олгох унаа, хоолны зардал				
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалт	12	Сургалтад хамрагдсан иргэдээс байнгын ажилтай болсон иргэний тоо (шимтгэл төлөгч ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийг алиныг оруулна)	3,382	<b>1,535</b>
		Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосны дараах				
		Мал маллах, малын ашиг шим боловсруулах сургалт /сүү, цагаан идээ боловсруулах/				
		Мал маллах, малын ашиг шим боловсруулах сургалт /мал маллах арга ухаан/				
	Залуучуудын сургалт, зөвлөгөө	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд зохион байгуулах	13	Сургалт, мэдээлэл авсан 18-34 насны залуучуудын тоо	1,851	<b>1,053</b>
	Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт	Мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт	14	Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо		<b>817</b>



САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	15	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	2,198	<b>1,652</b>
			16	Санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс хувиараа хөдөлмөр эрхлэх болсон хүний тоо	1,101	-
			17	Санхүүгийн дэмжлэг авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь	55.2	<b>60.0</b>
		Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох	18	Финтекээр эргэлтийн хөрөнгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	-	-
			19	Финтекээр эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгосон тоо	-	-
	Малчдыг малжуулах	Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	20	Санхүүгийн дэмжлэг авсан малчин өрхийн тоо	993	<b>1,059</b>
			21	Гэрээт малчнаар ажилдуулах		<b>97</b>
	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	Шилдэг "Старт-Ап" залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгох  "Старт-Ап" залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг, сургалт, зөвлөгөө, менторын үйлчилгээ	22	Гарааны бизнесийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуучуудын тоо		<b>46</b>
			23	Гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан залуучуудын тоо	1,412	<b>1,500</b>
	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг		24	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын тоо		<b>964</b>
Ажил олгогчийг дэмжих	Ажил олгогчид урамшуулал олгох /6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан/	25	Байнгын ажилтай болсон иргэдийн тоо	73	<b>311</b>	
Түрээсийн дэмжлэг үзүүлэх	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт	26	Арга хэмжээнд хамрагдсан аж ахуй эрхлэгчийн тоо	1,285	<b>1,107</b>	

	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх		27	Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан бараа, бүтээгдэхүүний тоо	-	-
	Хүүхэд харах төвийн түрээсийн болон урсгал зардлын дэмжлэг үзүүлэх		28	Түрээсийн дэмжлэгт хамрагдсан хүүхэд харах төвийн тоо	-	<b>184</b>
			29	Бусад дэмжлэгт хамрагдсан хүүхэд харах төвийн тоо	-	-
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ		30	Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо		<b>80</b>
	Санхүүгийн дэмжлэг	Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг	31	Санхүүгийн дэмжлэг авч хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа ХБИ-ний тоо	872	<b>745</b>
		Төрийн бус байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг	32	Дэмжлэгт хамрагдсан төрийн бус байгууллагын тоо		<b>25</b>
		Аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэг	33	Тохируулгатай ажлын байраар хангагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо		<b>22</b>
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	Өмнөх сургалт	34	Мэргэжлийн, давтан болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан ХБИ-нээс байнгын ажлын байртай болсон буюу хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүний эзлэх хувь	35.3	<b>40.0</b>
		Дараах сургалт	35			
	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	36			
		Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт	37	Мэргэжлийн болон давтан сургалтад (танхимын болон үйлдвэрлэлийн) хамрагдсан ХБИ-ний тоо	354	<b>477</b>
	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг	Түрээсийн дэмжлэг	38	Ажлын байрны түрээсийн дэмжлэгт хамрагдсан ХБИ-ний тоо	132	<b>283</b>
		Борлуулалтын дэмжлэг үзүүлэх	39	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан аж ахуй эрхлэгч ХБИ-ний тоо		-
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг	Ажил олгогчид урамшуулал олгох/ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/	40	Байнгын ажилтай болсон ХБИ-ний тоо	34	<b>149</b>	

ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Мод тарих	41	Мод тарих арга хэмжээнд хамрагдаж түр ажлын байртай болсон иргэдийн тоо	9,466	<b>11,497</b>
	Нийтийг хамарсан ажил	42	Нийтийн хамарсан ажил хийж түр ажлын байртай болсон иргэдийн тоо	13,422	<b>11,545</b>
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	43	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж түр ажлын байртай болсон иргэдийн тоо	724	<b>940</b>
	Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ	44	Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн төрийн бус байгууллагын тоо		-
	Хүүхэд хамгаалагч үйлчилгээ	45	Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /ахмад/	346	<b>150</b>
ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЭЭР ТОДОРХОЙЛСОН ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭ	Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх" төсөл	46	Бүртгүүлсэн залуучуудын тоо	2,765	-
		47	Төсөлд хамрагдсан залуучуудын тоо	1,228	<b>5,000</b>
		48	Ажлын байранд дадлагдажсан залуучуудын тоо	820	-
		49	Байнгын ажлын байранд зуучлагдсан залуучуудын тоо	410	-
	Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх	50	Тогтмол ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	-	<b>5,000</b>
	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх	51	Дэмжлэгт хамрагдсан суралцагчдын тоо		<b>400</b>
	Өмнөх мэдлэг, ур чадварын үнэлгээг улсын хэмжээнд зохион байгуулах	52	Үнэлгээнд хамрагдсан иргэдийн тоо	560	<b>300</b>
	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ	53	Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдийн тоо	-	<b>300</b>
		54	Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	-	

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	Хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	55	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын албан хаагчдаас сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	920 /давхардсан тоо/	<b>1,000 давхардсан тоо/</b>
	Хөдөлмөрийн туай хуулийн шинэчилсэн найруулга болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах	56	Хөдөлмөрийн тухай хууль, түүний дүрэм, журмуудыг танилцуулах сургалт, мэдээлэлд хамрагдсан ажил олгогчийн тоо	4,988	<b>5,000</b>
	Хөдөлмөр эрхлэлтийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах	57	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний тухай мэдээлэл авсан хүний тоо	5,823	<b>7,000</b>





МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1/16

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл  
ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын  
жишиг хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Нэгдсэн удирдамжийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Т.Бадрахбаяр), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (Ц.Нямсүрэн), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (Б.Батбаатар)-д тус тус даалгасугай.

3. Нэгдсэн удирдамжид заасан үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын жишиг хэмжээг үндэслэл болгож, 2023 онд хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж, мэргэжил арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Т.Бадрахбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Чинзориг)-т үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2021 оны А/96, 2022 оны А/43, 2022 оны А/54 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.АЮУРСАЙХАН

D: 2023 on 02 sar tushaal  
151230043

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын 2023 оны 02 дугаар сарын  
06-ны өдрийн А/16 дугаар тушаалын  
хавсралт

**ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА  
(ХӨТӨЛБӨР)-Г  
ХЭРЭГЖҮҮЛЭХ  
НЭГДСЭН УДИРДАМЖ,  
ЗАРДЛЫН ЖИШИГ  
ХЭМЖЭЭ**

# 1.

## ЗОРИЛГО



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2, 3 дугаар бүлэгт заасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, дэмжих арга хэмжээ болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг төрийн байгууллагуудын зүгээс зорилтот бүлгийн иргэдэд нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалттайгаар хүргэж, хэрэгжилтийг ханган, үр дүнг үнэлэхэд энэхүү нэгдсэн удирдамжийн зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг дараах байдлаар эрэмбэлэн хэрэглэнэ:

- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;**
- **Монгол Улсын бусад хууль;**
- **Засгийн газрын тогтоол;**
- **Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол;**
- **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал;**
- **Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаал;**
- **Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаал.**

# 2.

## НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (үйлчилгээ, арга хэмжээ)-нд ашиглагдаж буй түгээмэл нэр томьёо болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тодорхойлолтыг дараах байдлаар ойлгоно.

### 2.1. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling)

Ажил хайгч, ажилгүй иргэний талаар мэдээлэл цуглуулах, хөдөлмөр эрхлэх чадварыг нь үнэлэх, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломжийн талаар дүгнэлт гаргах, тухайн иргэний ажил хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоотой нэгдмэл үйл ажиллагаа юм.

### 2.2. Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ – RPL (Recognition of Prior Learning)

Албан бус сургалт, амьдрах орчин, өөрийн туршлага, сонирхлоор сурсан мэргэжлийн ур чадвар, чадамжийг албан ёсоор үнэлж хүлээн зөвшөөрөх үйл явц юм.

### 2.3. Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах (Individual Employment Planning)

Ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний дүн болон эрэлт хэрэгцээгээ харгалзан боловсруулсан тухайн иргэний хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө юм.

### 2.4. Ажилд зуучлах (Job Mediation)

Ажил хайж байгаа иргэнд хүсэл, сонирхол, мэргэжил, чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход нь туслалцаа үзүүлэх үйлчилгээ хэлнэ.

### 2.5. Хөдөлмөр эрхлэх чадвар (Employability)

Хүний онцлог шинж чанар буюу дасан зохицох чадвар, ажил мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавхаа таньж мэдсэн байдал, хөдөлмөр эрхлэх чадавх боломж (мэдлэг, чадвар, ажлын туршлага, нийгмийн сүлжээ г.м) зэргээс бүрдэнэ.

### 2.6. Гарааны бизнес (Start-up)

Инновацыг хөгжүүлэх замаар хэрэглэгчдэд хүртээмжтэй, үнэ цэнтэй шийдэл бүтээх, тогтвортой ажиллах системийг төлөвшүүлэх зорилготой цогц үйл ажиллагааг хэлнэ.

**2.7. Тохируулгатай ажлын байр (Workplace adjustment)**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн онцлог хэрэгцээнд тулгуурлан ажиллах орчин нөхцөл, материал тоног төхөөрөмжийг бий болгон ажлын байраар хангах явцыг хэлнэ.

**2.8. Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт (Supported employment)**

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүндрэл зэргээс үл хамааран ажлын байранд шаардагдах ур чадварыг аажмаар олгож, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн ажлын байрны тохируулга хийх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжийг хэлнэ.

**2.9. Ажлын байрны дадлагажуулагч (Job Coaching)**

Ажлын байран дээр аж ахуйн нэгж байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, зохих арга зүйг эзэмшсэн хүнийг хэлнэ.



# 3.



## ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст үйлчилгээ авахаар хандаж буй иргэн, аж ахуйн нэгжид тухайн иргэн, аж ахуйн нэгжийн үйлчилгээ авах хэрэгцээ, зорилгод нь нийцүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг санал болгох зарчмыг баримтална.

### АЖИЛ ОЛГОГЧ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хандан ажилтан сонгож авах, шинэ болон нээлттэй ажлын байраа бүртгүүлэх, мэдээлэл авах зорилгоор хандан ирж буй ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг **Б-Х33-3** маягтын дагуу мэдээллийг бүртгэн авч, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

### АЖИЛ ХАЙГЧ

#### Нэгдүгээр алхам: БҮРТГЭЛ



- Ажил хайгч иргэнийг **Б-Х33-2**<sup>1</sup> маягтын дагуу бүртгэн авч нэгдсэн мэдээллийн санд мэдээллийг оруулна.

#### Хоёрдугаар алхам: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ПРОФАЙЛИНГ)<sup>2</sup>



- **Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-ний аргачлал**<sup>3</sup>-ын дагуу **Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний Маягт 1**<sup>4</sup>-ийг ашиглан Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээг гүйцэтгэнэ. Хөдөлмөр эрхлэлтийн ажилтан нь үйлчилгээ авахаар ирсэн иргэний зорилгыг тодруулж, шаардлагатай тохиолдолд түүнд “Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)”-ний талаар танилцуулж, хүсэлтэд үндэслэн хийнэ.
- **Үнэлгээг цахимаар хийх боломжгүй тохиолдолд** хэвлэсэн Маягт 1-ийг иргэнээр бөглүүлэхгүй, ярилцлагын хэлбэрээр зохион байгуулна.

Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд дараах иргэдийг заавал хамруулна. Үүнд:

- “Ажилгүй иргэн”

1 Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/106 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

2 Хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ нь иргэнийг цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлэхэд чиглэнэ.

3 ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/288 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

4 ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/288 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэнийг;

- **"Ажил олоход хүндрэлтэй иргэн"**
  - Хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн;
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д заасан иргэн;
  - Хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, б сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн;
- **"Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн"**
  - Хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргээх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэн;
- **"Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдаж буй иргэн"**
- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** "Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (санхүүгийн дэмжлэгээс бусад)", "Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа"-нд хамрагдах хүсэлтэй иргэд.
  - Иргэн "Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ"-ний талаар мэдээлэл авсны дараа үнэлгээ хийлгэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүнд "Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний маягт 1"-ийг (цаасан эсвэл цахим хэлбэр) өгч бөглүүлнэ. Хэрэв иргэн үнэлгээ хийлгэхээс татгалзаж, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй бол үнэлгээг хийхгүй.
  - Тухайн иргэний үнэлгээ "А" бол ажилд зуучлах иргэн гэж үзэн, үнэлгээг дуусгаж 30 хүртэлх хоногийн хугацаанд ажилд зуучлах бөгөөд "Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө" хийх шаардлагагүй.
  - В, С, D үнэлгээ авсан иргэний хувьд "Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний маягт 2"<sup>1</sup>-ыг ашиглан ярилцлагын хэлбэрээр үнэлгээг гүйцэтгэнэ. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-г хийсний дараа "Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө"<sup>2</sup>-г хөдөлмөр эрхлэлтийн ажилтан иргэнтэй хамтран боловсруулна. Хувийн төлөвлөгөө боловсруулах үйл явц нь иргэнийг хамгийн тохиромжтой ажилд зуучлах замаар хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх, эсхүл дахин зуучлахад юуг, хэзээ хэрхэн хийх шаардлагатайг харуулсан логик дараалал юм. Хувийн төлөвлөгөөний агуулга нь иргэнийг тогтвортой, цалинтай ажилтай болоход чиглэсэн байх шаардлагатай.

Гуравдугаар алхам. "ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ХУВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ"-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ



Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас тухайн иргэний хэрэгцээ, зорилгод нийцүүлэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

<sup>1</sup> ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/288 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

<sup>2</sup> ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/288 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

Ингэхдээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсөв, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хуваарьт туссан хамрагдах хүний тооноос хэтрүүлэхгүй.

Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг В болон С үнэлгээтэй иргэнтэй хамтран боловсруулах ба дараах байдлаар үйлчилгээ, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгана.

Үнэлгээ	Үйлчилгээ	Арга хэмжээ
<b>В</b>	2 хүртэлх үйлчилгээ	2 хүртэлх арга хэмжээ
<b>С</b>	3 хүртэлх үйлчилгээ	3 хүртэлх арга хэмжээ

*Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-г гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэхийг хориглоно.*

*Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (профайлинг)-г гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлэхийг хориглоно.*

## ӨМНӨХ МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ҮНЭЛГЭЭ

Албан бус сургалт, амьдрах орчин, өөрийн туршлага, сонирхлоор сурсан мэргэжлийн ур чадвар, чадамжийг албан ёсоор үнэлж хүлээн зөвшөөрөх үйл явц юм.

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL)-нд хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд хүргүүлнэ.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт арга зүйч нь үйлчилгээ авахаар ирсэн иргэнд үнэлгээний зарчмыг танилцуулж **өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL)-ний аргачлал**-ын дагуу үнэлгээг хийнэ.
- Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL)-г нийслэлийн хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт хариуцан зохион байгуулах ба холбогдох Мэргэжлийн зөвлөлтэй хамтран хийнэ.
- Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хөдөлмөр эрхлэлтийн өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL)-нд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийн үнэлгээг Олон Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр мэргэжлийн холбоо үнэлгээний багтай хамтран зохион байгуулна.

3 Батлагдсан төсвийн хүрээнд Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүний зардлыг ХЭДС-гаас санхүүжилнэ.

# 4.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ



### 4.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилгүй иргэдэд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлнэ.

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь ажлын 3 өдрөөс хэтрэхгүй байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн болон сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, мөн эрх бүхий хөдөлмөрийн хувийн бирж, сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.



### 4.2. Ажилд зуучлах үйлчилгээ

Ажилд зуучлах үйлчилгээ нь ажлын байрыг судлах, ажил олгогчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, ажил хайгчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажлын байранд тохирох эсэх, хувь хүний болон ур чадварын үзүүлэлтийг шинжлэх, хоёр талын хэрэгцээнд нийцсэн туслалцаа үзүүлэх үйлчилгээ хамаарна.

- 4.2.1. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling);
- 4.2.2. Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах;
- 4.2.3. Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ (RPL);
- 4.2.4. Ажилд зуучлах (байнгын, цагийн, түр).

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагад тавих шаардлага стандартыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх байгууллага нь харьяалах орон нутгийн болон салбарын онцлог, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогод нийцүүлэн ажилд зуучлах үйлчилгээний байгууллагын стандарт, журмуудыг боловсруулан мөрдөж, үйлчилгээний гүйцэтгэлийг хэмжих шинэ арга хэрэгсэл боловсруулж хэрэгжүүлнэ.

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартын дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж буй орчныг үйлчлүүлэгчдэд ээлтэй, илүү үр дүнтэй, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх боломжтой болгон шинэчлэн зохион байгуулна.

- Үйлчлүүлэгчдийг хүлээж авах хэсэгт компьютер байрлуулах;
  - Үйлчлүүлэгчид өөрсдийгөө бүртгэх, ажил хайх боломж бүрдүүлэх;
  - Ганцаарчилсан зөвлөгөө өгөх, ажил хайх сургалт семинар, бүлгээр зөвлөгөө хийх боломж бүрдүүлэх;
  - Ажил хайгч иргэдийг тохирсон ажлын байранд зуучлах (жоб матчинг хийх);
  - Нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах (цагийн ажилд зуучлах болон хувийн зуучлалын байгууллагын үйлчилгээ);
  - Ажлын байрны нэгдсэн зар мэдээ, сүлжээ, цахим хуудас бий болгох;
  - Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээний талаарх сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулах.
- Ажил олгогч нарт зориулсан үйлчилгээг сайжруулах, ажлын байранд зуучлах үйлчилгээнд доорх арга хэмжээг хамруулна:
  - Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн сан дахь ажлын байрны захиалгын тоо, чанарыг сайжруулах, шинэчлэх үйл явцыг тодорхой болгох;
  - Ажлын байрны захиалгыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох боломжтой болгох;
  - Ажил олгогчдод шаардлагатай ажилтныг холбож өгөх, мэдээллийн үйлчилгээ (онлайн зуучлалын үйлчилгээ);
  - Ажил олгогчид ажлын байрны захиалгаа бүртгүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан болон бусад хувийн хэвшлийн ажлын байрны мэдээллийн санг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;
  - Ажил олгогчийн ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг тогтмол хугацаанд авч хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулах.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахад чиглэсэн ажилд зуучлалын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх гарын авлага, зөвлөмжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар боловсруулна.
- Аймаг, нийслэлийн хэмжээнд хөдөлмөрийн нэгдсэн болон төрөлжсөн бирж ажиллуулах (цагийн ажилд зуучлах болон хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагын үйлчилгээ) нэгдсэн зар мэдээ, сүлжээ, цахим хуудас бий болгох, сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага, стандартын дагуу тодорхойлж, стандартын шаардлага хангасан дүгнэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар гаргах ба бүртгэж, гэрчилгээ олгоно.

### 4.3. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ



Ажил хайгч иргэнийг ажлын байр, түүнд тавигдах шаардлага, ажил мэргэжлийн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем (Ejob)-д иргэний мэдээллийг оруулж бүртгэх үйлчилгээнээс бүрдэнэ.



Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөрийн зах зээлд оролцогч ажил олгогч байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем (Ejob)-д бүртгэх, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангахад чиглэнэ.

Мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд ажил хайх, ажил олоход туслалцаа үзүүлэхэд чиглэсэн тодорхой ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ажил мэргэжлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн мэдээллийн сангийн боловсруулсан мэдээллийг ажил хайгч иргэдэд хүргэх, олон нийтэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах суурь үйлчилгээ хамаарна.

- 4.3.1. Ганцаарчилсан байдлаар хандах үед мэдээллээр хангах;
- 4.3.2. Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр мэдээлэл өгөх;
- 4.3.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл;
- 4.3.4. Мэдээллийн самбар, гудамж, талбайн мэдээллийн дэлгэц;
- 4.3.5. Хэвлэмэл материал (ном, лавлагаа, мэдээллийн эмхэтгэл, товхимол, сэтгүүл).



## Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зардлын жишиг хэмжээ

№	Үйлчилгээ	Зардлын төрөл, дээд хэмжээ	
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ (төгрөг)	Ганцаарчилсан	15,000
		Бүлгээр	11,000
2	Ажилд зуучлах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ (төгрөг)	Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling)	9,500
		Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах	3,500
		Байнгын, цагийн, түр ажилд зуучлах	7,000

### Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд зарцуулах зардлын төрлүүдэд:

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг бүлгээр болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулсан багшийн зардал, тодорхой нарийн мэргэжлийн талаарх зөвлөгөө, мэдээлэл өгсөн мэргэшсэн зөвлөхийн зардал, ажил, мэргэжлийн талаарх танилцуулга хийх (тухайн ажлын байранд уялдуулах зардал) зөвлөгөө мэдээлэл өгөхөд шаардлагатай хэрэглэгдэхүүний зардал, Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл хийх, гарын авлага, зөвлөмж, зурагт хуудас хэвлүүлэх, сурталчилгаа хийх, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн мэдээлэл, судалгаа гаргах зардал, хөдөлмөрийн хувийн биржүүдэл ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлсэн үйл ажиллагаанд олгох санхүүжилтийн зардлуудыг багтаана.

### Ажилд зуучлах үйлчилгээний зардлын төрлүүдэд:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, бүртгэл, тайлангийн маягтууд хэвлэх, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэлийн маягт /ажлын байрны бүртгэл Б-ХЗЗ-1, ажил хайгч иргэний бүртгэл Б-ХЗЗ-2, ажлын байрны захиалгын бүртгэл Б-ХЗЗ-3/ -ын дагуу ажил хайж буй иргэн, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, ажлын байрны захиалгыг маягтаар авах зардал, ажлын байрны захиалгын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, ажлын байрыг судлах, хөдөлмөрийн биржүүдэд хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааны санхүүжилт олгох, ажил олгогч байгууллага болон ажил хайгч иргэдтэй байнгын эргэх холбоотой ажиллах, лавлах утасны зардал, ажил олгогчидтой уулзалт зохион байгуулах/уулзалт товлож ярилцлага хийх/, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, тайлангийн боловсруулалт, гарын авлага, зөвлөмж, хэвлэмэл хуудас хэвлүүлэх, ажил хайгч иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цай, кофе, г.м зардлуудыг багтаана.

Нийтлэг үйлчилгээний зардлыг дараах төрөл, зүйлээр зарцуулахыг хориглоно.

Үүнд: Тавилга, тоног төхөөрөмж, өдөрлөг, яармаг, болон хоол.

# 5.

## ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Зохион байгуулалт	Зардлын жишиг хэмжээ
1	Суурь ур чадварын сургалт	Ажил олоход хүндрэлтэй иргэн	Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд хамруулан, шаардлагатай иргэдэд хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг хамтран боловсруулж, Суурь ур чадварын сургалтад заасан сургалтыг зохион байгуулна.	Нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 30,000 төгрөг
<p>1.1. Суурь ур чадварын сургалтыг мэргэшсэн зөвлөх багшаар, эсхүл мэргэшсэн зөвлөх бүхий сургалтын байгууллагаар, эсхүл эдгээрийг хослуулан гэрээний дагуу өдрөөр, цагаар зохион байгуулж болно.</p> <p>1.2. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (3-ХЭДХ-1В маягтын дагуу)</p> <p>1.3. Сургалтыг хөдөлмөрийн хувийн бирж болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн бүртгэлийн гэрчилгээтэй сургалтын төв гэрээний дагуу зохион байгуулна.</p> <p>1.4. Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага, сургалтын төв, хөдөлмөрийн хувийн биржтэй хамтран боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээр батлуулна.</p> <p>1.5. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын байгууллагын сургагч багш нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс зохион байгуулсан чадавхжуулах сургалтад хамрагдаж сургагч багшийн эрх авсан байна.</p> <p>1.6. Ажлын байран дахь харилцаа, сэтгэл зүйн сургалтыг сургагч багшаар, эсхүл мэргэшсэн зөвлөх бүхий сургалтын байгууллагаар, эсхүл эдгээрийг хослуулан гэрээний дагуу өдрөөр, цагаар зохион байгуулж болно.</p> <p>1.7. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан нэгж, албан хаагчдын оролцоог хангаж, харилцан уялдаатайгаар зохион байгуулна.</p>				
2	Танхимын мэргэжлийн сургалт	Ажилгүй иргэн, Ажил олоход хүндрэлтэй иргэн	Танхимын сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт “Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөр”-ийн дагуу, 21 аймаг, алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрэлтэд үндэслэн зохион байгуулна.	<b>Хүснэгт 1:</b> Танхимын мэргэжлийн сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээг мөрдөнө.
<p>2.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрх бүхий сургалтын байгууллагуудаас (Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллага) сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллана.</p> <p>2.2. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (3-ХЭДХ-1В маягтын дагуу)</p> <p>2.3. Сургалтын хөтөлбөрийг ХНХСҮСИ-ээр батлуулж, дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>2.4. Сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд суралцах хугацааг БСШУСайдын баталсан 2015 оны А/150 тушаалаар баталсан мэргэжлийн чиглэл, индекс тийгүүлэн тогтооно.</p> <p>2.5. Төгсөлтийн үнэлгээг холбогдох журмын дагуу ХНХСҮСИ нь мэргэжлийн зөвлөл, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, чадамжийн гэрчилгээ олгоно.</p>				

- 2.6. Танхимын мэргэжлийн сургалт зохион байгуулах сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.6.2. Холбогдох журмын дагуу бүртгүүлсэн, сургалт зохион байгуулах бүртгэлийн гэрчилгээтэй зөвшөөрөлтэй, мэргэжлийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага байх;
- 2.6.3. Сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад нийцсэн, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг хангахуйц байх;
- 2.6.4. Насанд хүрэгчдийн сургалт заах арга зүй, ур чадвар бүхий үндсэн багштай байх;
- 2.6.5. Сургалтын стандарт нөхцөлийг хангасан онолын болон дадлагын байр, танхимтай байх;
- 2.6.6. Сургалт нь онол, дадлага буюу лабораторийн ажил, үйлдвэрлэлийн дадлагын хэсгүүдээс бүрдэх бөгөөд онолын сургалт нь нийт сургалтын 30 хувиас ихгүй байх;
- 2.6.7. Холбогдох бусад шаардлага.
- 2.7. Нийслэлийн төвийн 6 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага 3 дугаар сард багтаан эрхийн бичгээр сургах иргэдийн тоо, мэргэжлийн чиглэлийн саналаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд хүргүүлэх ба институт нь 4 дүгээр сарын 2 дахь хоногоос эхлэн сургалтыг төлөвлөн зохион байгуулна. Мөн мэргэжлийн сургалтад суралцаж төгссөн иргэдийн мэдээллийг 7 дугаар сарын эхний хагаст багтаан харьяалах дүүргүүдэд хүргүүлнэ.
- 2.8. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нийт сургалтын 20 хүртэл хувийг 9 дүгээр сараас хойш зохион байгуулж болно.

3	Үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт	Ажилгүй иргэн, Ажил олоход хүндрэлтэй иргэн	Сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дагуу зохион байгуулна.	<b>Хүснэгт 2:</b> Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээг мөрдөнө.
<p>3.1. Үйлдвэрлэл дээрх сургалтыг 3 долоо хоног буюу ажлын 15 хоногоос 6 долоо хоног буюу ажлын 30 хоногт ажил олгогчийн боломжит хугацаанд нийцүүлэн зохион байгуулна.</p> <p>3.2. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (3-ХЭДХ-1В маягтын дагуу)</p> <p>3.3. Сургалтын хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээр батлуулж, дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>3.4. Сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд суралцах хугацааг Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын баталсан 2015 оны А/150 тушаалаар баталсан мэргэжлийн чиглэл, индекст нийцүүлэн тогтооно.</p> <p>3.5. Төгсөлтийн үнэлгээг холбогдох журмын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь мэргэжлийн зөвлөл, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, чадамжийн гэрчилгээ олгоно.</p> <p>3.6. Сургалт зохион байгуулах бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага, аж ахуй нэгж байна.</p> <p>3.7. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн орон нутагт үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах тухай зар мэдээллийг 5 дугаар сард багтаан аж ахуйн нэгжүүдэд зарлан мэдээлж, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг нэгтгэнэ. Зар мэдээлэл тухайн жилд багтаан үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж иргэнийг ажилд авах хүсэлтэй, боломжтой аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн байна.</p> <p>3.8. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг нэгтгэж, үйлдвэрлэл дээрх сургалтын тухайн жилийн нийт эрэлтийн мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 6 дугаар сарын эхний 7 хоногт багтаан хүргүүлнэ.</p> <p>3.9. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар үйлдвэрлэл дээрх сургалтын тухайн жилийн эрэлтийн мэдээллийг хүлээн авч, төсөвлөсөн хөрөнгө, бүс нутаг, хүн амын тоо болон бусад үзүүлэлтийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын зохион байгуулах боломжит сургалтын хэмжээ, квотыг хуваарилна.</p>				

- 3.10. Уг квотод нийцүүлэн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл дээрх сургалт явуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн материалыг судалж, шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулна. Квотод багтаан шаардлага хангаагүй аж ахуйн нэгжийн оронд нэмэлтээр хүсэлт хүлээн авч болно.
- 3.11. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах шаардлага хангасан аж ахуйн нэгжийн холбогдох материал, гэрээний хувийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, санхүүжилтийг тухай бүр шийдвэрлүүлнэ.
- 3.12. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зохион байгуулах сургалтын зардлыг холбогдох бичиг баримтыг үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тухай бүр санхүүжүүлнэ.
- 3.13. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулахтай холбоотой аливаа маргаан, зөрчлийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага бүрэн хариуцна.
- 3.14. Сургалтын дадлагын хэсгийг аж ахуйн нэгж буюу ажил олгогч, онолын хэсгийг зохион байгуулагч байгууллага мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 3.15. Сургалтын хугацааг хувь хүний эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чадамжийн нэгжийн хөтөлбөрт үндэслэн уян хатан тогтоож болох бөгөөд нийт үргэлжлэх хугацаа нь 3-6 долоо хоног, 7 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.
- 3.16. Аж ахуйн нэгж 5-аас дээш хүнийг дадлагажуулан ажиллуулах тохиолдолд 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.
- 3.17. Аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг үр дүнгийн гүйцэтгэлд үндэслэн зардлын жишгийн дагуу нөхөн олгоно.
- 3.18. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах ажлын байр, цахилгаан, багаж, тоног төхөөрөмж зэрэг материаллаг болон материаллаг бус зардлыг аж ахуйн нэгж өөрөө хариуцна.
- 3.19. Ажил олгогчийн хэрэгцээ, суралцагчийн хүсэлтийг харгалзан сургалтын хугацаа уян хатан байх бөгөөд сургалтын хугацаанд ногдох санхүүжилтийг олгоно.
- 3.20. Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулж, ажиллах хүчин авах хүсэлтэй аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан тухай холбогдох баримт бичиг, материалыг бүрдүүлж, холбогдох байгууллагад хандана. Үүнд:
  - 3.20.1. Тухайн салбарт үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг нотолсон аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, Монгол Улсын хуулийн этгээд байх;
  - 3.20.2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтнуудтай, улмаар үйл ажиллагаа нь өргөжиж, шинээр ажилтан авах эрэлт хэрэгцээ бий болсон байх;
  - 3.20.3. Суралцагч үйлдвэрлэл дээр дадлага эзэмших боломжоор хангагдсан байх (дадлагын тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цех, талбайтай, дагалдуулан сургах ур чадвар бүхий дадлагажуулагч багштай, мастер, мэргэшсэн мэргэжилтэн, инженер, сургагчийн нөөцтэй г.м);
  - 3.20.4. Дадлагын сургалтын хөтөлбөр, агуулга нь чадамжийн нэгж бүрээр тодорхойлогдсон байх бөгөөд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байх;
  - 3.20.5. Сургалтын хугацаанд үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, дүрэм журмыг мөрдүүлэх;
  - 3.20.6. Суралцагчдад сургалтын дадлагын хугацаанд нь ажил үүрэгт нь тохирсон цалин хөлс, урамшууллыг зохих журмын дагуу олгохоо нотолсон байх;
  - 3.20.7. Үйлдвэрлэл дээрх сургалтын суралцагчдын 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангаж, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг зөвшөөрсөн байх;
  - 3.20.8. Холбогдох бусад шаардлага.
- 3.21. Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах аж ахуйн нэгж нь өөрийн үндсэн ажилтны тоо 2-5 хүртэл байвал 3 хүртэл хүнийг, 6 буюу түүнээс их байвал шинээр бий болох ажлын байрны тоогоор буюу 4-өөс дээш хүнийг үйлдвэрлэл дээр сургах тухай хүсэлтээ ирүүлнэ.
- 3.22. Үйлдвэрлэл дээрх сургалтын онол, дадлагын хичээлийн зардлыг ажил олгогчид шилжүүлэн олгох бөгөөд онолын хичээлийн 20 хувьд зориулсан сургалтын зардлыг онолын хичээлийг явуулахаар тухайн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллагын дансанд шилжүүлж, баримтыг бүрдүүлнэ.

- 3.23. Үйлдвэрлэл дээрх сургалтын үйл ажиллагаанд зарцуулах нийт зардлыг сургалт эхлэхэд 70 хувь, сургалтын үйл ажиллагаа дуусаж, суралцагч мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалт өгсний дараа шалгалтад тэнцсэн болон ажлын байраар хангагдсан суралцагчийн тоог үндэслэн үлдсэн 30 хувийг тус тус олгоно.
- 3.24. Үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь монгол иргэдийг гадаад ажилтан, ажилчдыг дагалдуулан ажиллуулж байгаа бол шалгаруулалтад давуу тал болно.

4	Аж ахуй эрхлэлтийн сургалт	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч; Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай бол тухайн ажилтнаар эсхүл сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр сургалтыг зохион байгуулна.	Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 15,000 төгрөг,  Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосны дараах сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 25,000 төгрөг
			Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдахгүй иргэд сургалтад хамрагдаж болно.	Аж ахуй эрхлэлтийн сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 40,000 төгрөг

- 4.1. Арга хэмжээнд хамрагдаж, санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авахаар төсөл боловсруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтыг санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн өмнө ба дараа зохион байгуулна.
- 4.2. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (3-ХЭДХ-1В маягтын дагуу)
- 4.3. Сургалтын агуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институт, мэргэжлийн холбоо, мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулна.
- 4.4. Аж ахуй эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургагч багш нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтээс зохион байгуулсан чадавхжуулах сургалтад хамрагдаж сургагч багшийн эрх авсан байна.
- 4.5. Сургалтын байгууллагыг аж ахуй эрхлэлтийн эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтаас сонгох бөгөөд жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран гаргана.
- 4.6. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнө 1 хоног, олгосны дараа 2 хоног байна. 3 хоногийн сургалт нь 21 академик цагаас доошгүй хөтөлбөртэй байна.
- 4.7. Аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын үйл ажиллагаанд хуваарилсан төсвийг тухайн багшийн замын зардал болон томилолтын зардалд зарцуулж болно.
- 4.8. Жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг хамрагдсан иргэдийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих, хяналт тавих зорилгоор иргэд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, ажил олгогчдын оролцоотой туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг аж ахуй эрхлэлтийн сургалтын зардалд хуваарилсан төсвийн 5 хүртэл хувиар зохион байгуулж болно.
- 4.9. Аж ахуй эрхлэлтийн сургалтад бизнес эхлэх, бизнес хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төлөвлөгөө, төсөл боловсруулах, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж, үйл ажиллагаа эрхлэх чиглэлийн сургалтууд хамаарах бөгөөд иргэн эдгээр хөтөлбөрүүдээс сонгон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдана.



<b>5</b>	Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх болон гэрээт малчин өрх	Арга хэмжээг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулах эрх бүхий мэргэшсэн сургалтын байгууллагыг сонгож, гэрээ байгуулан зохион байгуулна.	3 өдөр – 40.000 төгрөг
<p>5.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх болон гэрээт малчин өрхөд мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт (мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах г.м), туршлага солилцох уулзалт зохион байгуулах зэрэг дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.</p> <p>5.2. Сургалтыг мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн эрх бүхий сургагч багшаар гэрээний дагуу зохион байгуулж болно;</p> <p>5.3. Туршлагатай сайн малчдаас суралцах, туршлага солилцох, дэлгэрүүлэх зорилготой уулзалт, хэлэлцүүлгийн төлөвлөгөөг хуваарилагдсан төсөвт багтаан тухайн аймаг, алслагдсан 3 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр батлуулан зохион байгуулж болно.</p>				
<b>6</b>	Залуучуудын сургалт, зөвлөгөө	15-34 насны залуучууд	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвүүдэд ажил олгогчдын байгууллагатай хамтран “In business” сургалтын модулийн дагуу зохион байгуулна.	Аж ахуй эрхлэлтийн сургалтын жишиг зардлын хэмжээгээр тооцно.
<p>6.1. Ажил олгогчдын байгууллагаас хамтран 2 өдрийн сургалтын арга хэмжээнд бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын залуучуудыг хамруулан зохион байгуулна.</p> <p>6.2. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (3-ХЭДХ-1В маягтын дагуу)</p> <p>6.3. Сургалтын хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтээр батлуулж, дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>6.4. Сургалтын эхний өдрийн арга хэмжээ “Бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй байя” модуль 8 цаг байх бол дараагийн өдрийн арга хэмжээ Бизнесийн санхүү төлөвлөлт модуль 7 цагийн арга хэмжээнээс бүрдэнэ.</p> <p>6.5. Оролцогчид багт хуваагдаж, багш, хөндлөнгийн мэргэжилтний дэмжлэггүйгээр сургалтын сонгон авсан бизнесийн бодит жишээ, туршлагад үнэлэлт дүгнэлт өгөх, гаргасан алдааг засах дасгал ажил хийх, ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар бизнес эрхлэх дадал, чадамж эзэмшүүлэхэд чиглэнэ.</p> <p>6.6. Сургалтын модуль нь оролцогчид хоорондоо харилцаа холбоо тогтоох, сургалтын явцад идэвхтэй оролцох, “суралцагч” болон “сургагч”-ийн үүргийг хослон гүйцэтгэж, загвар болгон сонгон авсан бизнесийн жишээ, туршлагыг тал талаас нь задлан шинжилж, дээрх үйлдлээс олж мэдсэн зүйлээ өөрсдийн бизнест тохиолдсон бэрхшээл, нөхцөл байдлыг хамгийн оновчтой даван туулах шийдлийг гаргахад ашиглах чадамж, туршлага эзэмшүүлэхэд чиглэнэ.</p>				
<b>7</b>	Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар сургалт	Ажил, хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд, Гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, Хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд	Танхимын сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт “Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөр”-ийн дагуу, 21 аймаг, алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрэлтэд үндэслэн зохион байгуулна.	<b>Хүснэгт 1:</b> Танхимын мэргэжлийн сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээг мөрдөнө.

- 7.1. Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн хөдөлмөр эрхлэх ур чадварт хийсэн үнэлгээнд үндэслэн мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон (танхим, цахим) сургалтыг зохион байгуулна. Үүнд:
  - 7.1.1. Цахим ур чадвар эзэмшүүлэх;
  - 7.1.2. Мэргэжлийн ур чадвар нэмэгдүүлэх;
  - 7.1.3. Хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар дээшлүүлэх.
- 7.2. Сургалтыг мэргэшлийн 2 дугаар түвшний чадамжийг олгох сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа 3 долоо хоног, 7 хоногт 20 цагаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.
- 7.3. Төгсөлтийн үнэлгээг холбогдох журмын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институт мэргэжлийн зөвлөл, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, чадамжийн гэрчилгээ олгоно.
- 7.4. Сургалтын хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээний судалгааны институтээр батлуулж, дүгнэлт гаргуулсан байна.
- 7.5. Сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд суралцах хугацааг Боловсрол, соёл шинжлэн ухааны сайдын баталсан 2015 оны А/150 тушаалаар баталсан мэргэжлийн чиглэл, индекс нийцүүлэн тогтооно.
- 7.6. Сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ (З-ХЭДХ-1В маягтын дагуу)



#### **АНХААРАХ АСУУДАЛ:**

1. Суурь ур чадварын сургалтын арга хэмжээнд Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг түлхүү хамруулах бөгөөд 40 хувиас багагүй байна.
2. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж болох бөгөөд бүх нийтийн болон амралтын өдрүүдэд зохион байгуулахгүй.

#### **ХОРИГЛОХ АСУУДАЛ:**

1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг төсвийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажилтан багшийн урамшуулал болон цалинд зарцуулахгүй.

**Хүснэгт 1: Танхимын мэргэжлийн сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ, төгрөгөөр**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн чиглэл	Ажилгүй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, ажил олоход хүндрэлтэй иргэний сургалт		Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт	
		Ажлын 5 өдөрт ногдох зардлын дээд хэмжээ	Нийт зардлын дээд хэмжээ	Ажлын 5 өдөрт ногдох зардлын дээд хэмжээ	Нийт зардлын дээд хэмжээ
<b>А.</b> ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, АН АГНУУР	1. Үр тариа, тэжээлийн ургамал тариалах	26,700	160,000	21,300	128,000
	2. Фермерийн аж ахуй	26,700	160,000	21,300	128,000
	3. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах (Ногоочин)	26,700	160,000	21,300	128,000
	4. Ойн аж ахуй, мод бэлтгэх	23,300	140,000	18,700	112,000
	5. Малчин	23,300	140,000	18,700	112,000
	6. Бусад	23,300	140,000	18,700	112,000
<b>Б.</b> УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	1. Машин механизм, төхөөрөмжийн оператор	46,700	280,000	37,300	224,000
	2. Машин механизм, төхөөрөмжийн засварчин	40,000	240,000	32,000	192,000
	3. Зүтгүүрийн машинч (Төмөр замын ажилтан)	40,000	240,000	32,000	192,000
	4. Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан	36,700	220,000	29,300	176,000
	5. Далд ба ил уурхайчин	36,700	220,000	29,300	176,000
	6. Баяжуулагч	33,300	200,000	26,700	160,000
	7. Зам, засвар үйлчилгээний ажилтан	36,700	220,000	29,300	176,000
	8. Бусад	33,300	200,000	26,700	160,000

<b>В.</b> БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР	1. Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр	30,000	180,000	24,000	144,000
	2. Хөнгөн үйлдвэрлэлийн сүлжигч, нэхэгч, кительчин	30,000	180,000	24,000	144,000
	3. Хатгамал, эсгий, давуу урлал	26,700	160,000	21,300	128,000
	4. Арьс ширэн урлал	26,700	160,000	21,300	128,000
	5. Гутал үйлдвэрлэл (Монгол, Буриад гутал эсгэх, оёх)	26,700	160,000	21,300	128,000
	6. Гар урлал, бэлэг дурсгал	26,700	160,000	21,300	128,000
	7. Модон эдлэл буюу гэр ахуйн мужаан	30,000	180,000	24,000	144,000
	8. Жижиг эдлэл үйлдвэрлэл (Чөдөр, ногт г.м)	26,700	160,000	21,300	128,000
	9. Хүнсний боловсруулах үйлдвэрлэл (мах, сүү)	30,000	180,000	24,000	144,000
	10. Хоол үйлдвэрлэл, тогооч	30,000	180,000	24,000	144,000
	11. Талх нарийн боов	23,300	140,000	18,700	112,000
	12. Сүү цагаан идээ боловсруулах	23,300	140,000	18,700	112,000
	13. Бусад	23,300	140,000	18,700	112,000
<b>Г.</b> БАРИЛГА БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	1. Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор	36,700	220,000	29,300	176,000
	2. Засал, чимэглэл	40,000	240,000	32,000	192,000
	3. Өрөг угсрагч	40,000	240,000	32,000	192,000
	4. Бетон арматур	43,300	260,000	34,700	208,000
	5. Цахилгаанчин	40,000	240,000	32,000	192,000
	6. Гагнуурчин	40,000	240,000	32,000	192,000
	7. Сантехникч	40,000	240,000	32,000	192,000
	8. Барилгын мужаан	40,000	240,000	32,000	192,000
	9. Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор	40,000	240,000	32,000	192,000

	<b>10.</b> Шилчин	33,300	200,000	26,700	160,000
	<b>11.</b> Дээвэрчин	33,300	200,000	26,700	160,000
	<b>12.</b> Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин	40,000	240,000	32,000	192,000
	<b>13.</b> Цахилгаан төхөөрөмжийн механикч (Тохируулагч)	40,000	240,000	32,000	192,000
	<b>14.</b> Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч	36,700	220,000	29,300	176,000
	<b>15.</b> Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	33,300	200,000	26,700	160,000
	<b>16.</b> Хөдөө аж ахуй машин механизм, тоног төхөөрөмжийн механикч, засварчин	40,000	240,000	32,000	192,000
	<b>17.</b> Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	36,700	220,000	29,300	176,000
	<b>18.</b> Бусад	33,300	200,000	26,700	160,000
<b>Д.</b> БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, АХУЙН БОЛОН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	<b>1.</b> Автомашины засвар	26,700	160,000	21,300	128,000
	<b>2.</b> Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар	26,700	160,000	21,300	128,000
	<b>3.</b> Дархан, мужаан, сийлбэр	23,300	140,000	18,700	112,000
	<b>4.</b> Телевизор, гар утасны засварчин	23,300	140,000	18,700	112,000
	<b>5.</b> Гутал засвар	23,300	140,000	18,700	112,000
	<b>6.</b> Жижиг эдлэлийн засварчин (Цүнх, цаг г.м)	20,000	120,000	16,000	96,000
	<b>7.</b> Үсчин	26,700	160,000	21,300	128,000
	<b>8.</b> Гоо засал	26,700	160,000	21,300	128,000
	<b>9.</b> Зочид буудлын үйлчлэгч, үйлчилгээний ажилтан	23,300	140,000	18,700	112,000
	<b>10.</b> Гэрийн үйлчлэгч, асрагч	20,000	120,000	16,000	96,000

<b>11.</b> Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан	23,300	140,000	18,700	112,000	
<b>12.</b> Аялал зуучлалын хөтөч, тайлбарлагч	23,300	140,000	18,700	112,000	
<b>13.</b> Худалдагч касс, нярав	23,300	140,000	18,700	112,000	
<b>14.</b> Зөөгч, Баармен	23,300	140,000	18,700	112,000	
<b>15.</b> Бусад	20,000	120,000	16,000	96,000	
<b>Е.</b> МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	<b>1.</b> Цахим ур чадвар (Мэдээлэл хайх, олж авах, Цахим орчинд бусадтай харилцах, Цахим контент бүтээх, Цахим орчинд аюулгүй байдлаа хангах)	20,000	120,000	16,000	96,000

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (суралцагч)-д ногдох зардлын жишиг хэмжээ нь тухайн мэргэжлийн болон давтан сургалтын зардлын хэмжээг 30 (гучин) хувиар нэмэгдүүлэн тооцсонтой тэнцүү байна.
- Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ тус бүрийн 30 (гучин) хувийг онолын хичээлд, 70 (далан) хувийг дадлагын хичээлд тус тус зарцуулна.
- Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээг "Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны танхимын, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардлын жишиг болгоно.
- Сургалтын зардлыг олгохдоо ажлын 5 хоногт ногдох зардлын дээд хэмжээгээр тооцон сургалтын ирцэд үндэслэн нийт зардлын дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй.



Хүснэгт 2: Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ, төгрөгөөр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн чиглэл	Ажилгүй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд, ажил олоход хүндрэлтэй иргэний сургалт		Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэний сургалт	
		Ажлын 5 өдөрт ногдох зардлын дээд хэмжээ	Нийт зардлын дээд хэмжээ	Ажлын 5 өдөрт ногдох зардлын дээд хэмжээ	Нийт зардлын дээд хэмжээ
<b>A.</b> Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	1. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа	75,000	450,000	52,500	315,000
	2. Ойн аж ахуй, мод бэлтгэх	62,500	375,000	43,800	262,800
	3. Бусад	56,300	337,800	39,400	236,400
<b>B.</b> Уул уурхай, олборлолт	1. Машин механизм, төхөөрөмжийн оператор	97,500	585,000	68,300	409,800
	2. Машин механизм, төхөөрөмжийн засварчин	97,500	585,000	68,300	409,800
	3. Зүтгүүрийн машинч (Төмөр замын ажилтан)	90,000	540,000	63,000	378,000
	4. Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан	97,500	585,000	68,300	409,800
	5. Далд ба ил уурхайчин	90,000	540,000	63,000	378,000
	6. Баяжуулагч	90,000	540,000	63,000	378,000
	7. Зам, засвар үйлчилгээний ажилтан	77,500	465,000	54,300	325,800
	8. Хүнд даацын тээврийн хэрэгслийн жолооч	82,500	495,000	57,800	346,800
	9. Бусад	75,000	450,000	52,500	315,000
<b>B.</b> Боловсруулах үйлдвэр	1. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	60,000	360,000	42,000	252,000
	2. Нэхмэл, оёдол болон хувцас үйлдвэрлэл	60,000	360,000	42,000	252,000
	3. Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	60,000	360,000	42,000	252,000
	4. Хэвлэх, дахин үйлдвэрлэх ажиллагаа	52,500	315,000	36,800	220,800
	5. Бусад	45,000	270,000	31,500	189,000

Г. Барилга болон техникийн үйлчилгээ	1. Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор	90,000	540,000	63,000	378,000
	2. Барилгын засал, чимэглэл	82,500	495,000	57,800	346,800
	3. Барилгын өрөг угсрагч	82,500	495,000	57,800	346,800
	4. Барилгын бетон арматур	90,000	540,000	63,000	378,000
	5. Барилгын цахилгаанчин	90,000	540,000	63,000	378,000
	6. Барилгын гагнуурчин	90,000	540,000	63,000	378,000
	7. Барилгын сантехникч	82,500	495,000	57,800	346,800
	8. Барилгын мужаан	82,500	495,000	57,800	346,800
	9. Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор	90,000	540,000	63,000	378,000
	10. Шилчин	82,500	495,000	57,800	346,800
	11. Дээвэрчин	82,500	495,000	57,800	346,800
	12. Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин	82,500	495,000	57,800	346,800
	13. Цахилгаан төхөөрөмжийн механикч (Тохируулагч)	82,500	495,000	57,800	346,800
	14. Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч	82,500	495,000	57,800	346,800
	15. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	82,500	495,000	57,800	346,800
Д. Мэдээллийн технологи	1. Программ кодлогч	79,500	477,000	55,700	334,000

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (суралцагч)-д ногдох зардлын жишиг хэмжээ нь тухайн үйлдвэрлэл дээрх сургалтын зардлын хэмжээг 30 (гучин) хувиар нэмэгдүүлэн тооцсонтой тэнцүү байна.
- Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ тус бүрийн 20 (хорин) хувийг онолын хичээлд, 80 (наян) хувийг дадлагын хичээлд тус тус зарцуулна.
- Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээг “Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ны үйлдвэрлэл дээрх сургалтын зардлын жишиг болгоно.
- Сургалтын зардлыг олгохдоо ажлын 5 хоногт ногдох зардлын дээд хэмжээгээр тооцон сургалтын ирцэд үндэслэн нийт зардлын дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй.

# 6.

## САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Зохион байгуулалт	Дэмжлэгийн хэмжээ
<b>Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг</b>				
1	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн,  Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч,  Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч,  Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчид	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жил бүрийн 4 дүгээр сард багтаан, 8 дугаар сараас хойш  төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ба санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулна.  Хоёрдугаар үе шатыг "Шарк танк" хэлбэртэй дүйцүүлэн зохион байгуулна.	5,000,000 - 10,000,000 хүртэлх төгрөг  5,000,000 төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.
<p>1.1. Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 30 ба түүнээс дээш насны иргэн, мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчийн<sup>1</sup> боловсруулсан ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилготой төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, 10.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар нэг удаа олгоно.</p> <p>1.2. Төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангаж, шударга өрсөлдөх боломжийг бүрэн хангасан байдлаар зохион байгуулна.</p> <p>1.3. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэгдүгээр үе шатанд санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэний боловсруулсан төсөл, эргэн төлөлтийн хуваарь, холбогдох бичиг баримтыг тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.</li> <li>• Хоёрдугаар үе шатанд эхний шатанд шалгарсан төсөл бүхий иргэний аж ахуй эрхлэх, санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх болон бусад нөөц боломжтой танилцаж, үнэлгээ хийх, төслийг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх талаар мэдээлэл солилцох, шаардлагатай бол хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг арга замаар иргэдэд ил тод, нээлттэй байдлаар шалгаруулалтыг хийнэ. Мөн төслийн санал ирүүлсэн иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно. Тухайн төслийн ажлын байр, тоног төхөөрөмжтэй газар дээр танилцаж, дүгнэлт гаргана.</li> </ul> <p>1.4. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэн бусадтай хамтран аж ахуй эрхлэх нь нээлттэй бөгөөд энэ тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх төсөл, төлөвлөгөөндөө хамтран ажиллах иргэдийн оролцоог тусгана.</p> <p>1.5. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн өөрийн харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараах бичиг баримтыг бүрдүүлж хандана:</p> <p>1.5.1. Санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл;</p> <p>1.5.2. Иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбар;</p> <p>1.5.3. Аж ахуй, бичил бизнес эрхлэх үйл ажиллагааны төсөл, төлөвлөгөө.</p> <p>1.6. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэл харгалзахгүйгээр зохион байгуулна. Шаардлагатай бол ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг бүлэглэн шалгаруулалтыг зохион байгуулна.</p>				

<sup>1</sup> Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийг төгсөгч хувиараа хөдөлмөр эрхлэх тохиолдолд тухайн орон нутагт санхүүгийн дэмжлэг олгох зорилгоор хуваарилсан хөрөнгийн 2 хувиас хэтрэхгүй хөрөнгийг зарцуулж болно.

- 1.7. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд зарцуулах нийт хөрөнгийн 70 хүртэл хувийг 4 дүгээр сард, үлдсэн 30 хувийг 9 дүгээр сард тус тус зарцуулахаар төлөвлөж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна.
- 1.8. Ажлын хэсэг иргэний хэрэгжүүлэх төслийн бодит төсөвт өртгийг санхүүжүүлэх зарчим баримтална.
- 1.9. Иргэдээс ирүүлсэн төслийг шалгаруулахдаа хэрэв өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу буюу хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хүрээнд эзэмшсэн мэргэжлийн дагуу үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт ирүүлсэн бол давуу тал болно. Энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын чадамжийн гэрчилгээг үндэслэл болгоно.
- 1.10. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төлөлтийг гэрээний дагуу иргэнээр төлүүлж, хяналт тавих ба эргэн төлөлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.
- 1.11. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг иргэнд олгохдоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөр, төслийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүнд давхардуулан олгохгүй.
- 1.12. Санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэнтэй тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллана.

2	Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч (Хамрах хүрээнд заасан зээлийн мэдээллийн нэгдсэн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй иргэн, аж ахуйн нэгж ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилгоор хамрагдаж болно.)	Санхүүгийн дэмжлэгийг техник технологи ашиглан (fintech) автоматжуулж, орчин үеийн шинэлэг хэлбэрээр олгох арга хэмжээг Улаанбаатар, Дархан хотуудад зохион байгуулна.	400,000 - 1,000,000 төгрөг
---	--	---	--	-------------------------------

- 2.1. Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг 400.0 мянган төгрөгөөс эхлэн 1 сар хүртэл хугацаатай олгох бөгөөд хугацаандаа зээлийг эргэн төлсөн тохиолдол бүрд зээл авах боломжит хэмжээг нэмэгдүүлж, 1.0 хүртэл сая төгрөгт хүргэнэ.
- 2.2. Дэмжлэгийг хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлнэ. Эхний удаа 400.0 мянга, хоёрдох удаа 600.0 мянга, гуравдах удаа 800.0 мянга, дөрөвдөх удаа 1.0 сая төгрөг хүртэл нэмэгдүүлэн олгох зарчмыг баримтална.
- 2.3. Арга хэмжээг Улаанбаатар хотод нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Дархан хотод аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (финтек) ашиглан цахим хэлбэрээр дамжуулан олгох санхүүгийн байгууллагатай байгуулах гэрээний үндсэн дээр хамтран зохион байгуулна.
- 2.4. Арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хариуцна.
- 2.5. Жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэд түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаагүй аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд энэхүү финтек богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдаж болно.

#### Малчдыг малжуулах

3	Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	Хөдөө, орон нутагт шилжин суурьших хүсэлтэй малчин өрх, Малгүй болон цөөн малтай өрх	21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн хөдөлмөрийн чадвартай 18-45 насны 2-оос доошгүй гишүүнтэй, малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамруулна.	4,000,000 төгрөг 5,000,000 төгрөг
---	---	---	---	--------------------------------------

- 3.1. Арга хэмжээг тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулна.
- 3.2. Малгүй болон 200 хүртэл толгой бог малтай мал маллах хүсэлтэй өрхийг хамруулан 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авах зориулалтаар зарцуулна.
- 3.3. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь буцаан мөнгөн хэлбэрээр төлнө. Малчин өрхийн өөрийн боломжид тулгуурлан боловсруулсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-г малчин өрх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон сум, хорооны Засаг дарга нарын гурвалсан гэрээнд хавсаргана.
- 3.4. Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоож, хавсаргана;
- 3.5. Арга хэмжээнд дараах шаардлагыг хангасан малчин өрхийг хамруулна:
  - 3.5.1. Арга хэмжээнд хамруулах хүсэлт гаргасан байх;
  - 3.5.2. 18-45 насны 2-доошгүй гишүүнтэй (бусад насны гишүүдийн тоо хамаарахгүй бөгөөд тайлангийн маягтад бусад гишүүдийн тоог тусгана.) малчин өрх байх;
  - 3.5.3. Хамрагдах малчин өрх нь малжуулах арга хэмжээнд хамрагдахдаа боловсруулсан төлөвлөгөө, төсөлтэй байх;
  - 3.5.4. Эргэн төлөлтийг хийх хуваарийг тусгасан төлөвлөгөө гаргасан байх.
- 3.6. Эргэн төлөлтийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлнэ.
- 3.7. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулах бөгөөд худалдан авч байгаа малын үнэ зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

4	<p>Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах</p>	<p>Хөдөө, орон нутагт шилжин суурьших хүсэлтэй малчин өрх, Малгүй болон цөөн малтай өрх</p>	<p>Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Улаанбаатар хотод оршин сууж байгаад хөдөөд, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага аймгийн төвд оршин сууж байгаад хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж, орлоготой болгох арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг - 4,000,000 төгрөг, Орон нутаг руу нүүхэд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэг (20-200 км – 150.000 төгрөг, 201-350 км – 350,000 төгрөг, 351 км –ээс дээш 500,000 төгрөг) Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн олгох нэг сард ногдох зардлын хэмжээ (Ажил олгогч малчин-12.5% буюу 68,750 төгрөг, Гэрээт малчин 11.5% буюу 63,250 төгрөг) нийт 132,000 төгрөг</p>
---	--	---	--	--

- 4.1. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Улаанбаатар хот болон аймгийн төвөөс суманд, сум хооронд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж, орлоготой болгох арга хэмжээг зохион байгуулна.
- 4.2. Гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажиллуулах нөхцөлтэй малжуулах 4.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож болно. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авах зориулалтаар зарцуулах ба 24 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй байна.
- 4.3. Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгохыг гэрээт малчин өрхийг ажиллуулах ажил олгогч малчин зөвшөөрсөн байх ба энэ тухай гэрээт малчин өрхийн 2 гишүүнтэй байгуулах гэрээнд тусгана. Ажил олгогч малчин мал худалдан авч өгөхөд дэмжлэг үзүүлж болно.
- 4.4. Гэрээт малчин өрх малчинтай байгуулсан гэрээг өөрийн буруугаас болж цуцлах тохиолдолд малжуулах санхүүгийн дэмжлэгийг буцаан төлж барагдуулна. Харин малчин ажил олгогчийн буруутай үйлдлээс болж гэрээ цуцлагдах тохиолдолд аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нөхцөл байдлыг судалж, гэрээний дагуу төлж барагдуулах, эсхүл тухайн цаг үед шууд төлж барагдуулах талаар шийдвэр гаргана. Энэ тухайг холбогдох гэрээнүүдэд тусгана.
- 4.5. Гэрээт малчин өрхийг ажиллуулах малчин нь бог малд шилжүүлснээр 600 болон түүнээс дээш тооны малтай, гэрээгээр мал маллах өрхийг авч ажиллуулах хүсэлт гаргасан малчин байна.
- 4.6. Аймаг, дүүрэг (алслагдсан 3 дүүрэг)-ийн гэрээт малчин авч ажиллуулах малчны (600 болон түүнээс дээш малтай) бүртгэл, судалгааг тухайн аймаг, дүүргийн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан, Засаг даргын тамгын газар, багийн Засаг даргатай хамтран оны эхний улиралд багтаан гаргаж, аймаг, дүүргийнхээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт, Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газарт хүргүүлнэ.
- 4.7. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан нь хамтран малчин ажил олгогчид гэрээт малчнаар ажиллах өрхийн бүртгэл, судалгааг танилцуулах, сонголт хийлгэх, сонгосон гэр бүлтэй холбогдох, харилцан тохиролцож гэрээ байгуулах, сургалтад хамруулах зэрэг зуучлалын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.8. Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээний ерөнхий загвар, дөрвөлсөн гэрээний ерөнхий загвар (ажил олгогч малчин, гэрээт малчин өрх, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, сумын Засаг даргын тамгын газар), малчин ажил олгогч, гэрээт малчин гэр бүлийг бүртгэх судалгааны маягтыг тус тус батална.
- 4.9. Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар төслийн хэрэгжилтийн тайлангийн маягт, гэрээт малчин өрхийн гишүүдийг сургах сургалтын хөтөлбөрийг батална. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулна. Гэрээт малчин өрхийн гишүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтыг холбогдох хөтөлбөр, гарын авлагын дагуу зохион байгуулна.
- 4.10. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сум, хороо, багийн Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд эрх үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллана.
- 4.11. Гэрээт малчин өрх нь 18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй, гэр бүлээрээ хөдөөд шилжин суурьшиж, 2-оос доошгүй жил гэрээт малчнаар ажиллах нөхцөлийг зөвшөөрч хүсэлт гаргасан, тухайн хаягтаа 1 жилийн хугацаанд оршин суусан байна.
- 4.12. Ажил олгогч малчин нь гэрээт малчин өрхийн 2 гишүүнийг сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр үндсэн цалинтай байхаар харилцан тохиролцож, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн гэрээ байгуулж, цалинжуулж ажиллуулна.
- 4.13. Ажил олгогч малчин болон гэрээт малчин өрхийн гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухай бүр тухайн жилд хуваарилагдсан хөрөнгөөс нөхөн төлж хөнгөлөлт үзүүлнэ.
- 4.14. Гэрээт малчин өрхийн гишүүд нь тухайн оршин суух газартаа түр шилжүүлэг хийлгэх болон нийгмийн даатгалын дэвтэр авах зэрэг холбогдох бусад зардлыг өөрөө хариуцна;
- 4.15. Гэрээт малчин өрхийн орон нутаг руу нүүх зардлыг суурьших сумын замын уртаас хамааруулан тооцож, 50-200 км-т 150.0 мянган төгрөг, 201-350 км-т 350.0 мянган төгрөг, 351 км-ээс дээш 500.0 мянган төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олгоно.
- 4.16. Гэрээт малчин өрхийн хүсэлтээр гэрээт малчнаар 2 жилийн хугацаанд тогтвортой ажиллуулах нөхцөлтэйгөөр малжуулах санхүүгийн дэмжлэг олгож болно.



Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох				
<b>5</b>	<p>Гарааны бизнесийн санааг баяжуулах, өрсөлдүүлэх, хөгжүүлэх зэрэг арга хэмжээг бизнесийн зөвлөх (ментор) арга хэмжээ</p>	<p>Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн;</p> <p>15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд;</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж буй залуучууд;</p> <p>“Оролцоо” төслийн төгсөгчид</p>	<p>Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, бүлгээр ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах, шалгарсан “Старт-Ап”-ын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг зохион байгуулах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулна.</p>	<p>Зардлын дээд хэмжээ – төвийн 6 дүүрэгт 12,000,000 хүртэл, аймаг болон алсын 3 дүүрэгт 6,000,000 хүртэл төгрөг</p> <p>(1 шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулан, ментор-ийн үйлчилгээ үзүүлэх зардал нь 6,000,000 хүртэл төгрөг байна.)</p>
<p>5.1. Мэргэжлийн байгууллага дараах дараалал бүхий арга зүй, агуулгаар сургалт, арга хэмжээг зохион байгуулна:</p> <p>5.1.1. Бизнесийн санаа, бизнесийн санаагаа хөгжүүлэх оролцоонд тулгуурласан сургалт;</p> <p>5.1.2. Загварчлах сэтгэлгээ (design thinking) буюу бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт;</p> <p>5.1.3. Бизнес модель хавтан (business model canvas) ашиглах сургалт;</p> <p>5.1.4. Гарааны бизнесээ эхлүүлэх (Start-up weekend) – Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг менторын туслалцаатайгаар хөгжүүлэх, гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн үйл ажиллагаа;</p> <p>5.1.5. Бэлтгэл хурдасгуур (Pre-accelerator) – Ментор 5 долоо хоногийн турш үргэлжлэх 5 удаагийн хөгжүүлэх, бойжуулах;</p> <p>5.1.6. Хөрөнгө оруулагчид, олон нийтэд төслөө танилцуулах өдөр (Demo day).</p>				
<b>6</b>	<p>Шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, санхүүгийн дэмжлэгийг аймаг, дүүргийн шилдэг гарааны бизнест олгох</p>	<p>Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн;</p> <p>15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд;</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж буй залуучууд;</p> <p>“Оролцоо” төслийн төгсөгчид</p>	<p>Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь тухайн жилийн 3 дугаар улиралд багтаан зохион байгуулна.</p>	<p>Эргэн төлөгдөх нөхцөлгүй – 10,000,000 төгрөг</p>

- 6.1. Аймагт аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг "Старт-Ап" залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулж, 10.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг олгоно.
- 6.2. Тэргүүн туршлага, шинэ технологид суурилсан шинэлэг бизнес санаа бүхий "Старт-Ап"-г сонгон шалгаруулах арга хэмжээг аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дараах байдлаар зохион байгуулна:
- 6.2.1. Залуучуудын гарааны бизнесийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тус бүрд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулна.
- 6.2.2. Аймгийн ажлын хэсэг тухайн аймагт шилдэг "Старт-Ап"-ыг, нийслэлийн ажлын хэсэг дүүргүүдэд шилдэг "Старт-Ап"-ыг сонгон шалгаруулна.
- 6.2.3. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн гарааны бизнес эхлүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй залуу, эсхүл залуучуудын бүлэгт арга хэмжээг зарлан мэдээлж, залуучуудыг бүртгэнэ.

- 6.2.4. Бүртгүүлсэн залуу, эсхүл залуучуудын бүлэгт гарааны бизнесийн боломж, сонгон шалгаруулалтын талаар мэдээлэл өгч, гарааны бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар сургалт, дараагийн шатанд аж ахуй эрхлэлт, бизнес загвар боловсруулах сэтгэлгээний сургалт зэргийн урьдчилан зохион байгуулж болно.
- 6.2.5. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн арга хэмжээг 3 өдөр (Сүүлийн 2 өдөр нь хагас, бүтэн сайн) зохион байгуулахаар сонгогдсон мэргэжлийн эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний үндсэнд хэрэгжүүлнэ.
- 6.2.6. Шалгарсан залуу, эсхүл залуучуудын бүлгийн үйл ажиллагаа тогтворжиж, бизнесийн ашгаа хүртэж эхэлтэл бизнесийн зөвлөх (ментор)-үүдтэй хамтарч, гэрээний үндсэн дээр дэмжлэг үзүүлж ажиллана.
- 6.2.7. Шалгарсан залуу, эсхүл залуучуудын бүлэгтэй аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гарааны дэмжлэг олгох тухай гэрээ байгуулж, хамтран ажиллана.
- 6.2.8. Сонгон шалгаруулалтад эхний байранд орсон залуу, эсхүл залуучуудын бүлгийг багцлан баг болгож, 5 долоо хоногийн бизнес хурдасгуурын үйлчилгээнд хамруулж шинэлэг бизнес санаагаа хэрэгжүүлэх боломжтой нь нотлогдсон багуудад жижиг зээлийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээ үзүүлж болно.

7	Улсын хэмжээний гарааны бизнесүүдийг өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, эргэн төлөх нөхцөлгүйгээр олгох	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн;	Улсын хэмжээний шилдэг "Старт-Ап"-ийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар тухайн жилийн 2 дугаар улиралд багтаан зохион байгуулна.	Эргэн төлөгдөх нөхцөлгүй - 1 дүгээр байр (нэг баг) 20,000,000 төгрөг, 2 дугаар байр (хоёр баг) 17,000,000 төгрөг, 3 дугаар байр (гурван баг) 15,000,000 төгрөг
---	---	---	---	---

- 7.1. Улсын хэмжээний шилдэг "Старт-Ап"-ийг зохион байгуулахдаа Олон улсын хэмжээнд хэрэгждэг хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр, арга зүйн эрх бүхий байгууллагатай хамтарч болно.
- 7.2. Улсын хэмжээний шилдэг "Старт-Ап"-аар шалгарсан залуу, эсхүл залуучуудын баг нь аймаг, нийслэлийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгт давхардан хамрагдахгүй.
- 7.3. Улсын хэмжээний шилдэг "Старт-Ап" арга хэмжээнд оролцож, шалгарсан бизнес санаа, бизнесийг сурталчлах зорилгоор реалити шоу зохион байгуулж болно.

<b>8</b>	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан	Ахмад настны төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрд төслийг сонгон шалгаруулна.	- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг-5,000,000 хүртэл төгрөг, - 4,000,000 төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана.
<p>8.1. Ахмад нь аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор боловсруулсан төслөө харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлэх ба төсөлд олгох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 5.0 хүртэл сая төгрөг байна.</p> <p>8.2. Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтоож, холбогдох гэрээнд тусгана.</p> <p>8.3. Төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад настан оршин суух харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.</p> <p>8.3.1. Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;</p> <p>8.3.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт;</p> <p>8.3.3. Иргэний үнэмлэхийн хуулбар;</p> <p>8.3.4. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх хугацаа, гарах үр дүн, санхүүжилтийн тооцоо болон бусад шаардлагатай зүйлийг тусгасан төсөл, төлөвлөгөөтэй байх;</p> <p>8.3.5. Бусад шаардлагатай лавлагаа.</p>				

**Ажил олгогчийг дэмжих**

<b>9</b>	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлснээс хойш ажил идэвхтэй хайж байгаа, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадаагүй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг ажлын байны тоогоор тооцож нэг удаа олгох	Ажил идэвхтэй хайж байгаа, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадаагүй иргэн	Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэг олгох тухай гэрээг ажлын байраар хангагдаж байгаа иргэний байнгын оршин суугаа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ажил олгогчтой байгуулж, санхүүжилтийг олгоно.	2022 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420,000 төгрөг, 2023 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000 төгрөг
----------	--	--	--	--

- 9.1. “Ажил олгогч” нь улсын бүртгэлийн болон татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч байнгын ажлын байранд ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршооны удирдлага байна.
- 9.2. Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэгийг авахаар гэрээ байгуулсан ажил олгогч урамшууллаа авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж холбогдох байгууллагад хандана:
- 9.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 9.2.2. Ажил олгогч, ажилтны хүсэлт;
- 9.2.3. Ажилтны иргэний үнэмлэхийн хуулбар;
- 9.2.4. Ажилтан зорилтот бүлгийн иргэн мөн болохыг нотолсон баримт бичиг, тодорхойлолт;
- 9.2.5. Хөдөлмөрийн болон бусад гэрээний хуулбар;
- 9.2.6. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл НДШ төлсөн тухай ТҮЦ машины тодорхойлолт;
- 9.2.7. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн татвар шимтгэлийн өргүй талаарх тодорхойлолт;
- 9.2.8. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй байгуулсан гэрээ;
- 9.2.9. Ажилтны цалингийн картны хуулбар;
- 9.2.10. Бусад.
- 9.3. Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно. (тасралтгүй 12 сар ажилласан боловч ажлаасаа гарсан иргэний тухайд ажил олгогчид дэмжлэг олгохгүй)
- 9.4. Ажил олгогч хамрах хүрээнд заасан иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэн гэрээг байгуулж, холбогдох урамшууллыг авна.
- 9.5. Ажил олгогч нь ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин, хөлсийг олгон шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.
- 9.6. Урамшууллыг олгохдоо хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөрдлөг болгон тухайн онд харгалзах байдлаар тооцно.

10

Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7) иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгох

Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэн

Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэг олгох тухай гэрээг ажлын байраар хангагдаж байгаа иргэний байнгын оршин суугаа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ажил олгогчтой байгуулж, санхүүжилтийг олгоно.

Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний нэг сарын цалингийн дээд хэмжээ 600,000 төгрөг

- 10.1. Ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэгийг авахаар гэрээ байгуулсан ажил олгогч урамшууллаа авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж холбогдох байгууллагад хандана:
  - 10.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
  - 10.1.2. Ажил олгогч, ажилтны хүсэлт;
  - 10.1.3. Ажилтны иргэний үнэмлэхийн хуулбар;
  - 10.1.4. Ажилтан зорилтот бүлгийн иргэн мөн болохыг нотолсон баримт бичиг, тодорхойлолт;
  - 10.1.5. Хөдөлмөрийн болон бусад гэрээний хуулбар;
  - 10.1.6. Ажилтны нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл НДШ төлсөн тухай ТҮЦ машины тодорхойлолт;
  - 10.1.7. Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн татвар шимтгэлийн өргүй талаарх тодорхойлолт;
  - 10.1.8. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй байгуулсан гэрээ;
  - 10.1.9. Ажилтны цалингийн картын хуулга;
  - 10.1.10. Бусад.
- 10.2. Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно. (тасралтгүй 12 сар ажилласан боловч ажлаасаа гарсан иргэний тухайд ажил олгогчид дэмжлэг олгохгүй)
- 10.3. Ажил олгогч хамрах хүрээнд заасан иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэн гэрээг байгуулж, холбогдох урамшууллыг авна.
- 10.4. Ажил олгогч нь ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин, хөлсийг олгон шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.
- 10.5. Иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан ажлын байраар хангасан тохиолдолд Үйлдвэрлэл дээрх сургалтын зардлын жишиг хэмжээгээр тооцон 1 хүртэлх сургалтын зардлыг холбогдох баримтыг үндэслэн нөхөн олгож болно.

11	Түрээсийн дэмжлэг үзүүлэх	Жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ - Улаанбаатар хот 250,000 төгрөг, Аймагийн төв 200,000 төгрөг, Сумын төв 150,000 төгрөг
----	---------------------------	--	---	--

- 11.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.
- 11.2. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлгээ хийж, тодорхойлсны үндсэн дээр улиралд нэг удаа нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.
- 11.3. Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж тухайн иргэдийн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайг холбогдох гэрээнд тусгаж, зохион байгуулагч талтай байгуулна.
- 11.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажлын байр түрээсэлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдах шийдвэр гаргасан иргэдэд үзүүлнэ.
- 11.5. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг тухайн ондоо багтааж дээд тал нь 6 сарын хугацаанд үзүүлэх ба хөнгөлөлтийг улиралд нэг удаа нөхөн олгоно.

- 11.6. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт эдлэх хүсэлтэй зорилтод бүлгийн дараах шаардлагыг хангасан иргэдийг шалгаруулж, хамруулна. Үүнд:
- 11.6.1. Энэхүү хөтөлбөрийн зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй, бичил бизнес эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байх;
- 11.6.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаагаа тасралтгүй 6 сар болон түүнээс дээш хугацаагаар явуулсан байх;
- 11.6.3. Хүчин төгөлдөр хугацаа бүхий түрээсийн гэрээтэй байх;
- 11.6.4. Бусад.
- 11.7. Иргэн нь түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэлийн, эсхүл үйлчилгээний аль нэг чиглэлээр хамрагдана. Үйлчилгээний төрөлд хүнсний болон бэлэн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа хамаарахгүй болно.

12	Эмэгтэйчүүд хүүхэд харах төвийн түрээсийн болон бусад дэмжлэг үзүүлэх	Хүүхэд харах төвийн үйл ажиллагаа эрхлэж буй эмэгтэйчүүд	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ - Улаанбаатар хот 250,000 төгрөг, Аймагийн төв 200,000 төгрөг, Сумын төв 150,000 төгрөг
----	---	--	---	--

- 12.1. Эрх бүхий хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нь 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар үйл ажиллагаа явуулж байсан байх шаардлагатай бөгөөд ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, өөрийн байранд үйл ажиллагаа явуулдаг бол урсгал (цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, хогны төлбөр г.м) зардлын хөнгөлөлтийг тухайн ондоо багтаан 6 сарын хугацаанд үзүүлэх ба хөнгөлөлтийг улиралд нэг удаа нөхөн олгоно.
- 12.2. Дэмжлэгт хамрагдах хүсэлтэй төв нь дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- А.** Эрх бүхий хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч ажлын байр түрээслэн үйл ажиллагаагаа тасралтгүй 3 сар болон түүнээс дээш хугацаагаар явуулсан байх, төлбөр төлсөн баримт; (Өөрийн байр бол гэрчилгээний хуулбар, урсгал зардал төлсөн төлбөрийн баримт)
- Б.** Хүчин төгөлдөр хугацаа бүхий түрээсийн гэрээтэй байх;
- В.** Холбогдох бусад бичиг баримт.

13	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэн	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг ийг ажиллуулна.	Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ – Улаанбаатар хот 700,000 төгрөг, Аймагийн төв 600,000 төгрөг, Сумын төв 400,000 төгрөг
----	------------------------------	--	---	---

- 13.1. Борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин, урамшуулал олгохгүй буюу борлуулалтын цэгт хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах, эсхүл зорилтот бүлгийн иргэдтэй харилцан тохиролцож, борлуулалтын орлогын тодорхой хувиар цалин, урамшууллыг олгох байдлаар зохион байгуулна.
- 13.2. Борлуулалтын цэгийг бизнес инкубатор төвөөр гэрээлэн ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд санхүүжилтийг "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-ээс хэтрүүлэхгүйгээр олгоно.
- 13.3. Борлуулалтын цэг нь бараа, бүтээгдэхүүн борлуулахад дэмжлэг үзүүлж, борлуулалтын захиалга хүлээн авах, сурталчлах, худалдан авагчидтай холбох зэрэг арга хэмжээг зохион байгуулна.



14	Санхүүгийн дэмжлэг авсан иргэдэд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх	Дорноговь, Өвөрхангай, Орхон аймгийн санхүүгийн дэмжлэг авсан иргэн	Дорноговь, Өвөрхангай, Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөлтэй хамтран зохион байгуулна.	
----	--	---	--	--

**! АНХААРАХ АСУУДАЛ:**

**Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд:**

1. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтээ 4 дүгээр сард багтаан гаргавал эхний хагас жилд, 8 дугаар сараас хойш гаргавал сүүлийн хагас жилд багтаан төсөлд санхүүжилт олгоно.
2. Төсөл сонгон шалгаруулалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

**Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах хүрээнд:**

1. “Улаанбаатар хотод оршин сууж байгаа иргэн” гэдэгт хөдөө, орон нутгаас нүүж ирсэн боловч хотын харьяалалгүй, харьяалалтай өрхийн гишүүнийг ойлгож болно.
2. Гэрээгээр мал маллах сонирхолтой өрхийн бүртгэл, судалгааг хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан оны эхний улиралд багтаан гаргаж нэгтгэн, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.

**ХОРИГЛОХ ЗҮЙЛС:**

**Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хүрээнд:**

Санхүүжилт хүрээгүйн улмаас тухайн сард сонгогдсон төсөлд санхүүгийн дэмжлэгийг олгоогүй тохиолдолд уг төслийн санхүүжилтийг дараагийн сонгон шалгаруулалтад оруулахгүйгээр шууд олгож болохгүй. Дараагийн сонгон шалгаруулалтад иргэний хүсэлт дахин авч болно.

# 7.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Зохион байгуулалт	Зардлын жишиг хэмжээ
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ (Job coaching)</b>				
1	Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний зохицуулалт	Ажил олгогч, төрийн бус байгууллага, Ажлын байрны дадлагажуулагч, хөгжлийн бэрхшээлтэй ажил хайгч иргэн, ажлын байраар хангагдсан иргэн	Сонгон шалгаруулалтыг 2-оос доошгүй удаа сонгон шалгаруулалтыг хийнэ. Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр 21 хоногийн хугацаанд сонгон шалгаруулалтыг зарлана. Ажил гүйцэтгэх гэрээг 6 сарын хугацаатай байгуулна.	Ажлын байрны дадлагажуулагчийн нэг цагийн ажлын хөлс 15,000 төгрөг, Ажлын байрны тохируулга 1,000,000-10,000,000 хүртэлх төгрөг Сургалтын зардал 1,000,000 хүртэлх төгрөг
<p>1.1. Бэлтгэл үе:</p> <p>1.1.1. Ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн системд бүртгэлтэй ажилгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгох, уулзалт хийх;</p> <p>1.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэлгээ хийх;</p> <p>1.1.3. Асран хамгаалагчтай уулзалт хийх;</p> <p>1.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирох ажлын байр хайх;</p> <p>1.1.5. Ажлын байранд үнэлгээ хийх;</p> <p>1.1.6. Тохирсон ажлын байранд зуучлах.</p> <p>1.2. Төвлөрсөн дэмжлэгийн үе:</p> <p>1.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэлгээ хийх;</p> <p>1.2.2. Ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах;</p> <p>1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх дэмжлэг;</p> <p>1.2.4. Ажил олгогчид үзүүлэх дэмжлэг;</p> <p>1.2.5. Гэр бүлийн дэмжлэг.</p> <p>1.3. Дэмжлэгийг аажмаар багасгах үе:</p> <p>1.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэлгээ хийх;</p> <p>1.3.2. Өөрийгөө үнэлэх, зорилгодоо хүрэх мэдрэмжийг төрүүлэх;</p> <p>1.3.3. Эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлох;</p> <p>1.3.4. Ажлын байрны чиг үүрэгт байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.</p> <p>1.4. Тогтвортой байдлыг дэмжих үе:</p> <p>1.4.1. Тогтмол хугацаанд нөхцөл байдлын талаар мэдээлэл авах;</p> <p>1.4.2. Асуудлыг шийдвэрлэхийн тулд дахин оролцох;</p> <p>1.4.3. Эргэх холбоог бий болгох.-</p>				

2	Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажил олгогч, төрийн бус байгууллагын ажлын байрны дадлагажуулагч дараах чиг үүрэг, хариуцлагыг хүлээнэ.	Төрийн бус байгууллага, ажил олгогч, ажил идэвхтэй хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажлын байрны дадлагажуулагч		
<p>2.1. Ажлын байрны дадлагажуулагч нь ажил идэвхтэй хайж буй хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэлийн системд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/22 тоот тушаалын нэгдүгээр хавсралт маягтын дагуу нэг ба түүнээс дээш хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэлгээний маягтын асуумжаар үнэлгээ хийж дүгнэлт гаргана.</p> <p>2.3. 2.2-ийн дүгнэлтэд үндэслэн хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээлд зуучлан ажлын байраар хангах, хөдөлмөрт бэлтгэх болон бусад дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт мэдээллийг ирүүлэн, холбогдох сургалтын байгууллагуудтай уялдаа холбоог ханган хяналт тавина.</p> <p>2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагчдад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг ажилд зуучлахаас өмнө шаардлагатай тохиолдолд зохион байгуулна.</p> <p>2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олгогчийн болон ажлын байрны мэдээллийг цуглуулж, тохирсон ажилд оруулж дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.6. Ажлын уулзалтыг ажил олгогч байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажлын байрны дадлагажуулагчдын оролцоотойгоор зохион байгуулна. Уулзалтын үеэр харилцан бие биеийнхээ хэрэгцээ, шаардлагын талаар тодорхой мэдээлэл авч, тохирох ажлын байрны орчин нөхцөл, ажил олгогчийн ажлын байрны тодорхойлолт, дотоод журамтай танилцана.</p> <p>2.7. Ажил олгогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангахаар зөвшилцөлд хүрснээр туршилт болон дагалдангаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулсны дараа ажилд дадлагажуулах явцыг эхлүүлнэ.</p> <p>2.8. Ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөөний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрэгцээ шаардлагатай дэмжлэгийг ажлын байрны дадлагажуулагч нь тухайн ажлыг саадгүй гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.9. Ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олгогчдод чиглэсэн сургалт зохион байгуулахаар тусгагдсан тохиолдолд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хуваарь ирүүлэн хамтран зохион байгуулна.</p> <p>2.10. Ажил олгогч байгууллагаас батлан гаргасан ажлын байрны чиг үүргийг мөрдлөг болгон ажиллуулах ба шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хэрэгцээ шаардлага, ур чадварт тохируулан өөрчилнө.</p> <p>2.11. Ажил олгогч, ажилтан албан хаагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газарт албан хүсэлт ирүүлэн хамтран зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.12. Ажлын байраар хангагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тогтвортой байдлын дэмжлэгт шилжих үед ахисан болон ахиц гараагүй түвшинг тодорхойлно. Хэрэв ахиц гараагүй тохиолдолд эргэх холбоог ажил олгогчийн оролцоотойгоор хяналт тавьж ажиллана.</p>				

- 2.13. Ажлын байрны дадлагажуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд зуучилж, 6 сар хүртэлх хугацаанд ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй эргэх холбоотой ажиллаж, шаардлагатай зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.
- 2.14. Ажлын байрны дадлагажуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрийгөө үнэлэх үнэлэмж, өөрийн зорилгодоо хүрч байгаа эсэх, ажлын байр солих, стресс гэх мэт эрсдэлт хүчин зүйлс байгаа эсэхийг ажиглана.
- 2.15. Ажил олгогчийн хамт олон, удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй хүний ар гэрийнхэн, ажлын байрны дадлагажуулагч нар өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцан авч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.16. Ажлын байрны дадлагажуулагчийн хийж гүйцэтгэсэн ажлын цагийн тооцоолол, тайлангийн маягтуудад хөтөлбөрийн 4.1-4.4 дэх заалт, ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээг нотлох баримтад тулгуурлан тусгана.
- 2.17. Ажлын байрны дадлагажуулагч нь ажил олгогчийн мэдээллийг цуглуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирох ажлын байрны үнэлгээг хийнэ. Үнэлгээний үр дүнд тулгуурлан тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тохирсон ажлын байранд зуучилна.

3	Ажлын байрны дадлагажуулагчийн харьяалах ажил олгогч, төрийн бус байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Төрийн бус байгууллага, ажил олгогч	-	-
---	---	-------------------------------------	---	---

- 3.1. Ажлын байрны дадлагажуулагчийг холбогдох сургалтад хамруулж бэлтгэх, мэргэшүүлнэ.
- 3.2. Дадлагажуулагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- 3.3. Санхүүгийн дэмжлэгийг олгох, хяналт тавих, ажлын байрны дадлагажуулагчид цалин хөлс олгоно.
- 3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил олгогчид уг үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх, үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 3.5. Ажил олгогчид байгаа сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг зуучлах үйлчилгээнд бүртгүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, ажил олгогчидтой хамтран ажиллана.
- 3.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг, ойлголтыг өөрчлөх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- 3.7. Ажил олгогчийн захиалгаар дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээ хийх, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх, тооцоо судалгаа хийж хамтран ажиллана.
- 3.8. Ажлын байран дээр дадлагажиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй дагалднаар ажиллах гэрээ байгуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг мөрдөж ажиллана.
- 3.9. Шалгарсан ажил олгогч, төрийн бус байгууллагыг хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх олон улсын стандарт бүхий "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт"-д заавал хамрагдсан байхыг зөвлөнө.

4	Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажил олгогч, төрийн бус байгууллагын ажлын байрны дадлагажуулагч дараах тавигдах шаардлагыг хангасан байна.	-	-	-
---	--	---	---	---

- 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллаж байсан туршлагатай;
- 4.2. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой;
- 4.3. Багаар ажиллах, бусдыг манлайлах чадвартай;
- 4.4. Компьютерын хэрэглээний Word, Power Point, Excel программыг ашиглан илтгэл тавих, тайлан бичих чадвартай;
- 4.5. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголттой, энэ талаар сургалтад хамрагдсан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, түүнд тохирсон хэрэгцээ шаардлагын талаар мэдлэг, туршлагатай;
- 4.6. Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтад хамрагдсан байх;
- 4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тухайн ажлын байранд шаардагдах ур чадвар, техникийг үлгэрлэх замаар сургах чадвартай;
- 4.8. Өөрийн ажлын байранд зуучлахаар сонгосон хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхцөл байдал, ур чадвар, хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг ажил олгогчдод ойлгуулах, түүнийгээ тайлбарлах чадвартай.

<b>5</b>	Сонгон шалгаруулалт	Төрийн бус байгууллага, ажил олгогч, ажлын байрны дадлагажуулагч	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 21 хоногийн хугацаанд сонгон шалгаруулалтыг зарлана. Ажил гүйцэтгэх гэрээг 6 сарын хугацаатай байгуулна. Сонгон шалгаруулалтыг 2-оос доошгүй удаа сонгон шалгаруулалтыг хийнэ.	-
----------	---------------------	--	---	---

- 5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тасралтгүй гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай, төрийн бус байгууллага сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.
- 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн хариуцлагын хүрээнд ажиллуулах зорилготой, хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2-т заасан үүргээ биелүүлээгүй ажил олгогч, нэн тэргүүнд хамрагдана.
- 5.3. Цогцарга хэмжээний сонгон шалгаруулалтын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэйгээр олон нийтэд зарлана.
- 5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй сурталчлан ажиллана.
- 5.5. Ажил олгогч, төрийн бус байгууллага нь цогц арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан бол гэрээнд заагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80-аас доошгүй хувийг тогтвортой ажлын байраар хангасан байна.
- 5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил олгогч, төрийн бус байгууллагатай ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээ үзүүлэх 6 сарын хугацаатай гэрээ байгуулна.
- 5.7. Гэрээ байгуулснаас хойш 6 сарын дараа явцын тайланг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлж гэрээний хэрэгжилтийг дүгнүүлнэ.
- 5.8. Сонгон шалгаруулалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах ба зарыг олон нийтэд хүргэсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор шаардлагатай материалыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хүлээн авна.
- 5.9. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

6	Санхүүжилт, цагийн гүйцэтгэлд хяналт тавих	Ажил олгогч, төрийн бус байгууллага, Ажлын байрны дадлагажуулагч	Ажлын байрны дадлагажуулагчийн нэг өдрийн ажлын цагийг 8 хүртэл цагаар / гүйцэтгэлээр/ тооцно. Амралтын цагаар ажилласан тохиолдолд нотлох баримтад үндэслэн гүйцэтгэлийн цагийг тооцож олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй нэг хүнд 60 хүртэлх цагийн үйлчилгээ үзүүлнэ.	-
---	--	--	--	---

- 6.1. Ажил олгогч, төрийн бус байгууллагын ажлын байрны дадлагажуулагчдын цагийн гүйцэтгэлийн тооцоог Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан зургаадугаар хавсралтын дагуу тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн хянаж гарын үсэг зурснаар нэгжийн дарга тооцооны нягтлан бодогч баталгаажуулан ажлын байрны дадлагажуулагчийн цалин хөлсийг байгууллагын дансанд шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд мөшгөх судалгаа хийнэ.

7	Хяналт тавих, тайлагнах	Төрийн бус байгууллага, ажил олгогч, ажлын байрны дадлагажуулагч	Ажлын байрны дадлагажуулагч нь сар бүрийн 25-ний дотор тайланг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт өгөх. Ажлын 10 хоногт багтаан санхүүжилтийг олгох. Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны явцад батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шинжилгээ үнэлгээг зохион байгуулан тайлангийн үр дүнг ХНХЯ-ны хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлнэ.	-
---	-------------------------	--	--	---

- 7.1. Ажил олгогч, төрийн бус байгууллага нь ажлын байрны дадлагажуулагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын байрны дадлагажуулагч нь тайлангаа сар бүрийн 25-ний дотор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлнэ. Тус тайланг хянасны үндсэн дээр ажлын 10 хоногт багтаан санхүүжилтийг олгоно.
- 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь цогц арга хэмжээнд хамрагдсан байгууллагуудын нэгдсэн тайланг хагас, бүтэн жилээр ХНХЯ –ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлнэ.
- 7.3. Цогц арга хэмжээг хэрэгжүүлж байгаа Ажил олгогч, төрийн бус байгууллагын мэдээллийг Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөрийн сайдын 2013 оны хамтарсан тушаалаар баталсан ажил хайгч иргэний бүртгэлийн ХЗЗ-2, ажил олгогчийн бүртгэл ХЗЗ-1А, ажлын байрны захиалгын мэдээлэл ХЗЗ-3 маягтыг бөглүүлж хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэлийн системд бүртгүүлж, мэдээллийн сан үүсгэнэ.
- 7.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар хамтран явцын хяналт шалгалтыг удирдамжийн дагуу зохион байгуулна.
- 7.5. 6 сараас дээш хугацаагаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, ажлын байрны тохируулга, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн акт, ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны хэрэгжилтэд тус тус хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцно.



- 7.6. Ажил олгогч нь туршилтын гэрээ байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг сар тутам нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, баталгаажуулаагүй тохиолдолд ажлын байраар хангасан үр дүн гэж тооцохгүй.
- 7.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/22 тоот тушаалын тав, долоодугаар хавсралт маягтын дагуу тайланг боловсруулан гүйцэтгэсэн арга хэмжээнүүдийн хамтран оролцогчдын мэдээллийг үнэн зөв, тодорхой тусган оруулах, фото зургаар баримтжуулсан байна.
- 7.8. Тохируулгатай ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим системээр хянана.
- 7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулж, дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээнд хамруулсан хуулийн этгээдийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулна.
- 7.10. 7.5. дахь заалтын хэрэгжилт нь хангагдаагүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон бол гэрээг сунгаснаас хойших нөхөн гүйцэтгэлийн хөлсийг олгохгүй.
- 7.11. Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагаанд зөрчил дутагдал хяналт шалгалтаар тогтоогдсон тохиолдолд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай гэрээ байгуулсан ажил олгогч, төрийн бус байгууллага нь хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн дэмжлэг

8	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлж ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх	4 болон 9 дүгээр сард зохион байгуулна. Зарласнаас хойш 21-28 хоногийн дотор, Баримт бичиг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор	10,000,000 хүртэлх төгрөг
9	Төрийн бус байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох	Сонгон шалгаруулалтыг гурван үе шаттай зохион байгуулна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг эхний шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Эхний шатны сонгон шалгаруулалтад төслийн баримт бичгийн бүрдэл, ажлын байр, тоног төхөөрөмжтэй танилцан шаардлага хангасан гэж үзэж буй төслүүдэд дүгнэлт гаргаж, жагсаалт үйлдэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлнэ.	20,000,000 хүртэлх төгрөг

			<p>Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийн шалгаруулсан төслийн баримт бичгүүдийг хянан баталгаажуулна. Төсөлтэй холбоотой санал, гомдол гарсан нөхцөлд тухайн төслийн ажлын байр, тоног төхөөрөмжтэй газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргана.</p> <p>Гуравдугаар үе шатыг “Шарк танк” хэлбэртэй дүйцүүлэн зохион байгуулна. Төрийн бус байгууллагууд нь шаардлага хангасан төслөө ажлын хэсэгт хамгаална.</p> <p>3 болон 9 дүгээр саруудад зохион байгуулна.</p> <p>Зарласнаас хойш 20 хоногийн дотор бичиг баримтыг хүлээн авна.</p>	
10	Ажил олгогчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэн байгуулсан ажил олгогчийн бизнесээ өргөжүүлэх, мөн 25 ба түүнээс дээш ажилтантай ажлын байрны төлбөр төлдөг ажил олгогч тохируулгатай ажлын байр бий болгох	<p>Сонгон шалгаруулалтыг гурван үе шаттай зохион байгуулна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг эхний шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Эхний шатны сонгон шалгаруулалтад төслийн баримт бичгийн бүрдэл, ажлын байр, тоног төхөөрөмжтэй танилцан шаардлага хангасан гэж үзэж буй төслүүдэд дүгнэлт гаргаж, жагсаалт үйлдэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлнэ.</p> <p>Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр</p>	30,000,000 хүртэлх төгрөг 50,000,000 хүртэлх төгрөг

			<p>үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийн шалгаруулсан төслийн баримт бичгүүдийг хянан баталгаажуулна.</p> <p>Төсөлтэй холбоотой санал, гомдол гарсан нөхцөлд тухайн төслийн ажлын байр, тоног төхөөрөмжтэй газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргана.</p> <p>3 дугаар үе шатыг “Шарк танк” хэлбэртэй дүйцүүлэн зохион байгуулна. Ажил олгогчид нь шаардлага хангасан төслөө ажлын хэсэгт хамгаална.</p> <p>3 болон 9 дүгээр саруудад зохион байгуулна. Зарласнаас хойш 20 хоногийн дотор бичиг баримтыг хүлээн авна.</p>	
11	Аж ахуй эрхлэлтийн сургалт (өмнөх ба дараах)	Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан ажил олгогч, төрийн бус байгууллагууд хамрагдана.	<p>4 дүгээр сард багтаан 8 дугаар сараас хойш зохион байгуулна.</p> <p>Зарласнаас хойш 21-28 хоногийн дотор</p> <p>Баримт бичиг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор тус тус зохион байгуулна.</p>	<p>Санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 17,000 төгрөг,</p> <p>Санхүүгийн дэмжлэг олгосны дараах сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ – 35,000 төгрөг</p>
12	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах	<p>Сургалтыг сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага хангасан гэрчилгээтэй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй, эрх бүхий сургалтын байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлнэ.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон зайн чиг баримжааны сургалт болон хөтөч, дохионы хэлмэрчийг бэлтгэх анхан шатны нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа нь ажлын 5-аас доошгүй хоног байх бөгөөд сургалтыг эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон иргэнтэй хамтран зохион байгуулна.</p>	Сургалтын зардлыг “Мэргэжлийн болон давтан сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”-гээр санхүүжүүлнэ.

## Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх

13	Түрээсийн дэмжлэг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэдэд бараа, бүтээгдэхүүн борлуулахад нь дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх	Хөтөлбөрт заасан ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэхэд дараах баримтыг үндэслэн олгоно. Иргэн бол тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлж байгааг нотлох баримт бичиг; Ажил олгогч бол хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан ажил олгогч болохыг нотлох баримт бичиг; Ажлын байрны түрээсийн гэрээ; Түрээсийн төлбөр төлснийг батлах дансны хуулга;	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ – Улаанбаатар хот 250,000 төгрөг, Аймгийн төв 200,000 төгрөг, Сумын төв 150,000 төгрөг
----	-------------------	--	--	--

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх

14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангаж, цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын төрийн бус байгууллагад байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой ажлын байраар хангаж 12 сараас доошгүй хугацаагаар цалин олгож нийгмийн даатгал төлсөн ажил олгогч, дотоодын төрийн бус байгууллагыг дэмжих	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь байнгын ажлын байртай болж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон урамшуулалд хамрагдсан ажил олгогчийн талаарх мэдээллийг “Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сан”-д бүртгэнэ. Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй, ажилгүй иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэн гэрээ байгуулж, холбогдох урамшууллыг авна. Урамшуулалд хамрагдах хүсэлтэй ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авах тухай шийдвэр, хүсэлтийг Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гаргаж, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох гэрээ”-ний загварын дагуу гэрээ байгуулж, талууд баталгаажуулна. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дээрх гэрээний хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж байгаа байнгын ажлын байрны тогтвортой байдалд тогтмол хяналт тавина. Урамшууллыг дараах баримт бичгийг үндэслэн аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага олгоно.	2022 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420,000 төгрөг, 2023 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000 төгрөг
----	--	--	--	--

15	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон хувиас илүү гарсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас илүү гарсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг тус бүр нэг удаа олгох</p>		<p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>• Ажил олгогч, ажилтны хүсэлт;</li> <li>• Ажилтны иргэний үнэмлэхийн хуулбар;</li> <li>• Ажилд авсан тушаалын хуулбар;</li> <li>• Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчинтэй акт;</li> <li>• Хөдөлмөрийн гэрээний хуулбар;</li> <li>• Ажилтны нийгмийн даатгалын цахим хуулбар;</li> </ul> <p>Ажил олгогчийн хүн амын орлогын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй талаарх тодорхойлолт;</p> <p>Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй байгуулсан гэрээ;</p> <p>Ажилтны цалингийн карт, банкны харилцах дансны хуулга;</p> <p>Бусад шаардлагатай баримт бичиг.</p> <p>Урамшууллыг олгохдоо хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөрдлөг болгон тухайн онд харгалзах байдлаар тооцно.</p>	
----	--	--	---	--

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа**

16	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд эдгээр чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчид хамтран ажиллана.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд тухайн жилдээ зохион байгуулна.</p>	-
----	--	--	--	---

17	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа хийж, эрх зүйн орчин, дүрэм журмыг сайжруулах тухай санал боловсруулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд эдгээр чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчид хамтран ажиллана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд тухайн жилдээ зохион байгуулна.	-
18	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд эдгээр чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчид хамтран ажиллана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулна.	-
19	Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах	Сургалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага, хувийн туслахын үйлчилгээ авах хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь хувийн туслах үйлчилгээ авснаар хөдөлмөр эрхлэх болж цалин орлоготой болсон нь нотлогдвол хувийн туслахын үйлчилгээний хөлсийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгох.  Улиралд 1 удаа хувийн туслахын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гүйцэтгэлийн тайланг үндэслэн батлагдсан жишгийг баримтлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.  Хувийн туслах бэлтгэх сургалтыг сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага хангасан гэрчилгээтэй, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй эрх бүхий сургалтын байгууллага гэрээлэн гүйцэтгэнэ. Хувийн туслах бэлтгэх сургалтын зардлыг батлагдсан жишгийн дагуу олгоно.	Хувийн туслах үйлчилгээний хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт тохирсон хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх нэг цагийн ажлын хөлс 8,000 төгрөг
20		Нийслэлийн 9 дүүрэг, орон нутгийн Монгол Абилимп 2022 уралдааны тэргүүн байр эзэлсэн 13 хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль, Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын чадамжийн төвүүд, Ажил олгогч дээр 13 мэргэжлийн чиглэлээр дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах.	



		Монголын Абилимпийн холбоо, Сэргээн засах сургалт үйлдвэрийн төвийн Мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургууль, Мэргэжлийн зөвлөл	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институттэй хамтран 2 удаагийн мэргэжлийн үнэлгээ хийх.  Оролцогчдыг дадлагажуулах сургалтын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай багаж хэрэгсэл, материал тоног төхөөрөмжөөр хангах.	-
--	--	--	---	---



**АНХААРАХ АСУУДАЛ:**

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх хүрээнд:**

**1.** Урамшууллыг олгохдоо хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөрдлөг болгон тухайн онд харгалзах байдлаар тооцно.

**ХОРИГЛОХ АСУУДАЛ:**

**1.** Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, ажил олгогч, төрийн бус байгууллага нь бусад арга хэмжээнд давхардаж хамрагдахгүй.

**2.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан иргэн, байгууллага нь гэрээний хугацаа дуусгавар болоогүй, гэрээний үр дүн хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд хөтөлбөрийн бусад арга хэмжээнд давхардаж хамрагдахгүй.

# 8.

## ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Зохион байгуулалт	Зардлын жишиг хэмжээ
1	Мод тарих	Ажилгүй иргэн, Ажил олоход хүндрэлтэй иргэн,	Нутгийн захиргааны байгууллага, Мэргэжлийн холбоо, ТББ-тай хамтран хавар 4-5 дугаар сард, намар 10-11 дүгээр саруудад зохион байгуулна.	Нэг цагийн ажлын хөлс – 4,500 төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэг цагийн зардал – 500 төгрөг
<p>1.1. Мод тарих, ногоон ажлын байрыг бий болгох, мод нийлүүлэх ажлыг Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн бүлгийн гишүүдийг сургах болон модны санхүүжилтийг төсвийн эрх бүхий Засаг дарга хариуцан ажиллах бөгөөд мод тарих, ажлын урамшууллыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.</p> <p>1.2. Мод тарих, түр ажлын байр бий болгох талаар Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга тухайн орон нутгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллана.</p> <p>1.3. Ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн зардлыг ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно.</p> <p>1.4. Мод тарих, түр ажлын байр бий болгоход нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнийг түлхүү хамруулах бөгөөд сум, хорооны бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2 болон түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй багуудыг зохион байгуулах, багийн гишүүн тодорхой шалтгааны улсаас ажиллаж байгаад ажиллаж чадахааргүй болсон тохиолдол багийн гишүүнийг ажилгүй иргэнээр нөхөн ажиллуулж болно.</p> <p>1.5. Тухайн бүлэг нь баг, хорооны нутаг дэвсгэрт болон бусад шаардлагатай байршилд мод тарих ажил хийж гүйцэтгэнэ.</p> <p>1.6. Мод тарих ажилд хамрагдах нийт иргэдийн 10 хүртэлх хувьд ахмад настныг хамруулж болно.</p>				
2	Нийтийг хамарсан ажил	Ажилгүй иргэн, Ажил олоход хүндрэлтэй иргэн,	Нутгийн захиргааны байгууллага, Мэргэжлийн холбоо, ТББ-тай хамтран тухай бүр зохион байгуулна.	Нэг цагийн ажлын хөлс – 4,500 төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэг цагийн зардал – 500 төгрөг
<p>2.1. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах төсөл, төлөвлөгөөг боловсруулж, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлнэ.</p> <p>2.2. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага төслийг хүлээн авч, бий болгох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо зэргийг хянан үзээд дэмжигдсэн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.</p> <p>2.3. Нийтийг хамарсан ажилд хамрагдах иргэдийг сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн зардлыг ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно.</p> <p>2.4. Тухайн орон нутгийн Засаг даргын үйл ажиллагаатай уялдуулан, хог, хаягдал цэвэрлэх ажлыг зохион байгуулна.</p>				

3	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэлтэй Ахмад мэргэжилтэн,  Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн орон нутгийнхаа Ахмад мэргэжилтний бүртгэлийг үүсгэнэ.	Нэг цагийн ажлын хөлс – 4,500 төгрөг
<p>3.1. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ шаардлагатай байгууллагууд (эрэлт хэрэгцээгээ ирүүлэхийг хүссэн урилга, мэдээлэл хүргүүлсэн байх) зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон хүсэлтээ аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлнэ.</p> <p>3.2. Зөвлөх үйлчилгээнд хамрагдаж буй байгууллага нь ахмад мэргэжилтнээр сургалт, ментор, дадлага удирдуулах байдлаар ажиллуулах ба ажилласан цагийн урамшууллыг тооцож, хамрагдсан байгууллагын ирүүлсэн тайлан, ажлын цагийн бүртгэлд үндэслэн урамшууллыг ахмад мэргэжилтэнд шууд олгоно.</p> <p>3.3. Урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байна.</p> <p>3.4. Хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтэнд аймаг, сум орон нутгийн захиргаа, бусад байгууллагаас үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл, шаардагдах материал түүхий эд, санхүүгийн болон дэмжлэг үзүүлэх ба гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь уялдуулан нэмэлт цалин хөлсийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож болно.</p> <p>3.5. Тухайн орон нутгийн ахмад мэргэжилтний жагсаалт, мэргэжлийн чиглэл болон ахмад мэргэжилтэн ажиллуулах шаардлагатай аж ахуйн нэгжийн мэдээллийг нээлттэй байршуулан холбон зуучлах ажлыг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухай бүр зохион байгуулна.</p>				
4	Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ	“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэлтэй Ахмад мэргэжилтэн,  Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зөвлөх үйлчилгээний захиалгад үндэслэн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулна.	Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хуваарилагдсан төсөвт багтаана.

- 4.1. Зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх ахмадын төрийн бус байгууллага нь төсөлд хамрагдах хүний тоо, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах төр хувийн хэвшлийн байгууллагын хүсэлт, ажиллах байршил, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төслийн холбогдох баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ.
- 4.2. Төслийн зориулалтаар хуваарилагдсан хөрөнгө, түүний зарцуулалт олон нийтэд ил тод, нээлттэй байна.
- 4.3. Төслийн үйл ажиллагаа эхлэхэд санхүүжилтийн 70 хувийг, төслийн явц, үр дүнг үндэслэн үлдэгдэл 30 хувийг санхүүжүүлнэ.
- 4.4. Төслийн үйл ажиллагаанд ахмадын баг, бүлгийг ажиллуулах ажил олгогч, төрийн захиргаа үйлчилгээний байгууллага нь ажиллах нөхцөл, байр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах болон ажлын нэмэгдэл хөлс, цалинг олгож болно.
- 4.5. Төсөлд хамрагдах ахмад мэргэжилтний зөвлөх баг нь төсөл хэрэгжүүлэх тухайн салбарт мэргэшсэн, 3-аас доошгүй гишүүнтэй байна. Төсөл хэрэгжүүлэх баг нь өөрийн үйл ажиллагааны талаарх асуудлаар удирдах дээд, төв байгууллагаараа уламжлан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллана.
- 4.6. Төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан байгууллага, зөвлөх баг нь тухайн салбарт хэрэгцээтэй байгаа ахмад мэргэжилтний туршлага, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, нарийн мэргэжлийн гарын авлага, арга зүйн зөвлөмж, ном товхимлыг төслийн өртөгтөө багтаан боловсруулж, хэвлэх зардал зарцуулж болно. Хэвлэх зардал нийт өртгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

5	Хүүхэд хамгаалагч үйлчилгээ	Цагдаагийн байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага, цэргийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 65 хүртэлх насны иргэн	Нийслэлийн 9 дүүргийн хороо тус бүр 1, 21 аймаг тус бүр 2 иргэнийг хүүхэд хамгаалагчаар ажиллуулна.	Нэг цагийн ажлын хөлс – 3,500 төгрөг
---	-----------------------------	---	---	--------------------------------------

- 5.1. Хүүхэд хамгаалагч бүр өдөрт 5-аас дээшгүй, сард 80-аас дээшгүй цаг ажиллана.
- 5.2. Хүүхэд хамгаалагчийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага хүүхэд хамгааллын чиглэлийн арга зүйгээр, цагдаагийн байгууллага гэмт, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн арга зүй, удирдлагаар хангаж ажиллана.
- 5.3. Цагдаагийн байгууллага нь хүүхэд хамгаалагчдын цагийн тооцоо, ажлын тайланг сар бүрийн сүүлийн 7 хоногт нэгтгэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ. Цагийн тооцоо, тайланг үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хүүхэд хамгаалагч (ахмад настан)-д урамшууллыг олгоно.
- 5.4. Хүүхэд хамгаалагчид дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
  - 5.4.1. Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага, цагдаагийн байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалж, зөвлөн туслах;
  - 5.4.2. Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага, цагдаагийн байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг иргэд, олон нийт, хүүхдүүдэд хүргэх, мэдээлэх;
  - 5.4.3. Хүүхдүүдийг эрсдэлд оруулж болзошгүй нөхцөл үүссэн тухай бүрд цагдаагийн байгууллагад мэдээлж, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авхуулах;
  - 5.4.4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн талаар цагдаагийн байгууллага, хамтарсан багт мэдээлэл өгөх;
  - 5.4.5. Цагдаагийн байгууллагаас батлагдсан дүрэмт хувцсыг заавал өмсөх бөгөөд ажилд гарах, ажлаас буух, дараагийн ажилтанд ажлаа хүлээлгэж өгөхдөө тухайн хэсгийн цагдаад заавал мэдэгдэж, цагаа бүртгүүлнэ.
- 5.5. Тухайн орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хамтран Цагдаагийн байгууллагын статистик мэдээлэлд үндэслэн Хүүхэд хамгаалагчийг ажиллуулах байршил бүхий ажлын төлөвлөгөөг гаргана.

### АНХААРАХ АСУУДАЛ:

1. Мод тарих, Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдэд олгосон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг тооцохгүй.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг амны хаалт, ажлын бээлий, хогны шуудай худалдан авахад зарцуулах бөгөөд холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
3. Мод тарих, нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн ажлын хөлс, зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн иргэний банкин дахь нэрийн дансанд шилжүүлнэ.
4. Нийтийг хамарсан ажилд хуваарилсан хөрөнгийн аймаг, алслагдсан 3 дүүрэгт 15 хувийг, нийслэлийн төвийн 6 дүүрэгт 20 хувийг хог, хаягдал цэвэрлэх үйл ажиллагааны зардалд зарцуулна.

### ХОРИГЛОХ АСУУДАЛ:

1. Нийтийг хамарсан ажлыг гэрээлэн гүйцэтгэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж нь хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүрэгт ажлыг нийтийг хамарсан ажлаар гүйцэтгүүлэхийг хориглоно.
2. Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд хамрагдаж буй ахмад мэргэжилтнүүд нь аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд давхардан хамрагдахгүй.

# 9.

## ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа				
№	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Хамрах хүрээ	Зохион байгуулалт	Эрх зүйн акт
1	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	15-34 насны залуучууд, Малчин залуучууд	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт зохион байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлнэ.
2	Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7-д заасан ажил олоход хүндрэлтэй иргэн	Ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоно.	Монгол Улсын Засгийн газар эсхүл Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн дагуу хэрэгжүүлнэ.
3	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх;	Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3. Дагалднаар суралцах ажилтны ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө. Холбогдох санхүүгийн баримтад үндэслэн улирал тутам нөхөн олгоно.		
4	Өмнөх мэдлэг, ур чадварын үнэлгээ - RPL (Recognition of Prior Learning)-г зохион байгуулах	Үнэлгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт зохион байгуулна.	-
5	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах	Судалгааны оролцогч талууд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт зохион байгуулна.	-
6	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх	Хохирогч эмэгтэйчүүд	Түр хамгаалах байр, Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Цагдаагийн байгууллага хамтран зохион байгуулна.	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тушаалын дагуу зохион байгуулна.



# 10.

## ТӨСВИЙН ХӨТӨЛБӨР ҮР ДҮН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

### ТАЙЛАГНАЛТ (Reporting)



- 10.1.** “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Төсвийн Хөтөлбөр”-ийн хүрэх үр дүнг “Үр дүнд суурилсан Төсвийн гүйцэтгэлийн” Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн маягт”-ын дагуу хагас болон бүтэн жилээр тайлагнана.
- 10.2.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг энэхүү удирдамжийн Хүснэгт 3-т заасан хүснэгтийн дагуу хэмжиж, тайлагнана.
- 10.3.** Үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах талууд Ejob цахим талбарыг ашиглан үйл ажиллагааны тайлан, мэдээллийг тогтмол оруулж, уг мэдээллээс тайлагнана.
- 10.4.** Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйл ажиллагааны хэрэгжилтийн тухайн сарын тайлан, мэдээг сарын эцсийн өдрөөр тасалбар болгож, дараа сарын 3-ны өдрийн дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны өдрийн дотор Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.
- 10.5.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, аймаг болон нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйл ажиллагааны хэрэгжилтийн тухайн сарын тайлан, мэдээг сарын эцсийн өдрөөр тасалбар болгож, дараа сарын 5-ны өдрийн дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг ажлын 3 хоногт багтаан нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлнэ.
- 10.6.** Төсвийн хөтөлбөрийн үр дүнгийн явцыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам сар бүр аймаг, дүүргээр гарган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байрлуулна.

### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ (Monitoring)

- 10.7.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх Төсвийн хөтөлбөрийн үр дүнгийн гүйцэтгэлд (тайлагналтын явцад) үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар улирал



тутам хяналт тавьж, дүгнэлт гарган, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт зөвлөмж өгнө.

- 10.8.** Төсвийн хөтөлбөрийн гүйцэтгэл болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны гүйцэтгэлд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2 удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар) жилд 1 удаа чанарын хяналт, шинжилгээг дараах байдлаар хийнэ.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт-шинжилгээний баг нь аймаг, дүүрэгт ажиллах жилийн төлөвлөгөөг гарган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргаар батлуулна.
  - Хяналт тавих үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.
  - Хяналт-шинжилгээний ажлын даалгавар, удирдамж, тайлангийн загварыг Төсвийн хөтөлбөрийн үр дүн болон Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлттэй уялдуулан гаргана.
  - Хяналтын явцад Төсвийн хөтөлбөрийн үр дүнд болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангахад чиглээгүй, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь баримтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
  - Хяналтын тайлан нь Ejob цахим талбарын сар тутмын тоон өгөгдөл, мэдээллийг баталгаажуулах чанарын мэдээлэл байх бөгөөд тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын холбогдох газрууд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох газар тус бүрд цахимаар болон хэвлэмэл байдлаар хүргүүлнэ.
- 10.9.** Үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг, хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг шаардлагатай хяналтыг тавьж ажиллана.

## ҮНЭЛГЭЭ (Evaluation, assessment)

- 10.10.** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институци хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг хэмжих тодорхойлох судалгааг гүйцэтгэнэ.
- 10.11.** Судалгааг түүврээр, үйл ажиллагаанд хамрагдсан иргэд болон хамрагдаагүй иргэдийг харьцуулах байдлаар, арга хэмжээнд хамруулахаас өмнөх болон дараах байдлыг харьцуулснаар гүйцэтгэнэ.
- 10.12.** Судалгааг гүйцэтгэх цах хүрээ, хүний болон санхүүгийн нөөцөөс хамаарч тухайн жилд үнэлэх үйлчилгээ, арга хэмжээнээс сонгон үнэлж болно.
- 10.13.** Үнэлгээний арга зүй, хамрах хүрээ, үнэлэх гол үзүүлэлт зэргийг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын холбогдох газруудаас санал авсны үндсэн дээр баталж, гүйцэтгэнэ.
- 10.14.** Судалгааг гүйцэтгэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

# ТУСЛАХ ХҮСНЭГТ

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ
<b>Ажилтан<sup>1</sup></b>	Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажиллаж байгаа Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн
<b>Ажил олгогч<sup>2</sup></b>	Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр хүнийг ажиллуулж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн
<b>Насанд хүрээгүй ажилтан<sup>3</sup></b>	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүн
<b>Хөдөлмөрийн гэрээ<sup>4</sup></b>	Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоны дагуу хийсэн тохиролцоо
<b>Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ<sup>5</sup></b>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо дагаж мөрдөх баримт бичиг
<b>Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл<sup>6</sup></b>	Ажлын байр, түүний байршил, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цаг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл
<b>Ажлын байр<sup>7</sup></b>	Иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор ажил гүйцэтгэх бүх байр
<b>Байнгын ажилтан<sup>8</sup></b>	Байнгын ажлын байранд албан ёсны гэрээтэй, ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцдаг, хөдөлмөрийн харилцаа нь холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэн
<b>Түр ажилтан<sup>9</sup></b>	Тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэн
<b>Улирлын ажилтан<sup>10</sup></b>	Улирлын чанартай байнгын ажлын байранд албан ёсны гэрээтэй, ажил олгогчоос татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцдаг, хөдөлмөрийн харилцаа нь холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэн
<b>Мэргэжил<sup>11</sup></b>	Тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогц
<b>Мэргэшил<sup>12</sup></b>	Тодорхой мэргэжлийн хүрээний ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшин
<b>Мэргэшлийн түвшин<sup>13</sup></b>	Ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлал
<b>Ур чадвар<sup>14</sup></b>	Байгууллагын стратеги зорилт болон албан тушаалд тавигдах шаардлагад нийцсэн, ажлыг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах шинж чанаруудын цогц

1 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт

2 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.1 дэх заалт

3 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.6 дахь заалт

4 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.9 дэх заалт

5 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.10 дахь заалт

6 Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.17 дахь заалт

7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.9 дэх заалт

8 Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ

9 Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ

10 Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ

11 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.2 дахь заалт

12 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.3 дахь заалт

13 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.7 дахь заалт

14 Future of jobs судалгааны тайлан

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ
<b>Зөөлөн ур чадвар<sup>15</sup></b>	Ажилтны хувийн зан чанарт тулгуурласан техникийн бус чадварууд
<b>Боловсролын түвшин<sup>16</sup></b>	Тухайн шатанд эзэмшвэл зохих боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээ
<b>Мэргэжлийн боловсрол<sup>17</sup></b>	Тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшил
<b>Техникийн боловсрол<sup>18</sup></b>	Техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн болон мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшил
<b>Насан туршийн боловсрол<sup>19</sup></b>	Бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагаа
<b>Мэргэжлийн суурь чадвар<sup>20</sup></b>	Нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшил
<b>Чадамж<sup>21</sup></b>	Хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд суралцагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшил
<b>Дадлагажих<sup>22</sup></b>	Ажлын байрны үндсэн чиг үүргийг сургалт, зааварчилгаатай хослуулан сургагч-ажилтныг дагалдуулан, цалин хөлстэй гүйцэтгэх хөдөлмөр эрхлэлт
<b>Ажлын байран дээр дадлага, туршлага, ур чадвар эзэмших<sup>23</sup></b>	Тодорхой мэргэшил, мэргэжлийн үнэмлэх олгодог эсэхээс үл хамааран уламжлалт болон албан, албан бус хэлбэрээр ажлын байран дээр туршлага, ур чадвараа дээшлүүлэх
<b>Сургалтын орчин<sup>24</sup></b>	Боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцаа
<b>Төлөвшил<sup>25</sup></b>	Суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогц
<b>Мэргэжилтэй ажилтан<sup>26</sup></b>	Тодорхой ажил эрхлэх, мэдлэг ба зохих ур чадварыг зориулалтын сургалтаар олж авсан, эсвэл эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан мэргэжилтэй хүн
<b>Бүтээмж<sup>27</sup></b>	Аливаа зорилтот үйл ажиллагааны үр дүн, амжилтыг илэрхийлэх хэмжигдэхүүн

15 Future of jobs судалгааны тайлан

16 Боловсролын тухай хуулийн 3.1.4 дэх заалт

17 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.4 дэх заалт

18 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.5 дахь заалт

19 Боловсролын тухай хуулийн 3.1.20 дахь заалт

20 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.6 дахь заалт

21 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт, MNS6541:2015, 4.10 дахь заалт

22 Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ

23 Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, ҮСХ

24 Боловсролын тухай хуулийн 3.1.10 дахь заалт

25 Боловсролын тухай хуулийн 3.1.11 дэх заалт

26 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

27 Бүтээмж тооцох аргачлал, ҮСХ

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй <sup>1</sup>	Хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа
Хөдөлмөрийн нөхцөл <sup>2</sup>	Хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчин
Амьдрах ухааны чадвар <sup>3</sup>	Гэр бүл төлөвлөлт, санхүүгийн мэдлэг болон эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах зан үйл, дадал төлөвшил, нийгэм сэтгэл зүйн чадвар
Ажил хайгч <sup>4</sup>	Ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэн
Ажилгүй иргэн <sup>5</sup>	Ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн
Ажил хийхэд бэлэн <sup>6</sup>	Хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулахаас татгалзахгүй байх
Ажилд зуучлах <sup>7</sup>	Ажил олгогчид ажилтан, ажил хайгчид ажил олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээ
Шинэ ажлын байр <sup>8</sup>	Эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаал
Хөдөлмөрийн насны хүн ам <sup>9</sup>	15, түүнээс дээш насны хүн ам
Ажиллах хүч <sup>10</sup>	Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн
Ажиллах хүчний эрэлт <sup>11</sup>	Ажил олгогчид хэрэгцээтэй хөдөлмөрийн үйлчилгээний хэмжээ
Хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү <sup>12</sup>	Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байх
Хөдөлмөр эрхлэлт <sup>13</sup>	Цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа
Хөгжлийн бэрхшээлтэй хүн <sup>14</sup>	Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүн

1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.1 дэх заалт

2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.4 дэх заалт

3 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 4.1.8 дахь заалт

4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.1 дэх заалт

5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.2 дахь заалт

6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.4 дэх заалт

7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.10 дахь заалт

8 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

9 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

10 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

11 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт


12 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

13 ҮСХ-ны хөдөлмөр эрхлэлтийн ойлголт тодорхойлолт

14 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1 дэх заалт

## ҮР ДҮНД СУУРИЛСАН УДИРДЛАГЫН ЗУРАГЛАЛ


Эргэх холбоо: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ, ТОХИРУУЛГА





# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН МАТРИЦ 2023

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨРҮҮД



- Үр дүн
- Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд
- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд